


2018

МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН



Гэрэл зургийг Regis Defurnaux

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ
ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИАР
ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИД
ХҮЛЭЭЛГЭСЭН ҮҮРГИЙН
ХЭРЭГЖИЛТ



Хүчирхийллийн эсрэг
үндэсний төв



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарин хөгжлийн агентлаг





**Хүчирхийллийн эсрэг
үндэсний төв**



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарын хөгжлийн агентлаг



ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИАР ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИД ХҮЛЭЭЛГЭСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН

Улаанбаатар хот
2018 он

АГУУЛГА

АГУУЛГА	3
ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ	4
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	5
МОНИТОРИНГИЙН БАГ	6
НЭГ. ОРШИЛ	7
1.1. Эрх зүйн орчин	7
1.2. Гэр бүлийн хүчирхийллийн өнөөгийн байдал	8
ХОЁР. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН ҮҮРЭГТ МОНИТОРИНГ ХИЙСЭН АРГАЗҮЙ	14
ГУРАВ. ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ	20
3.1. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үүргийн хэрэгжилт	20
Зохион байгуулалтын зохистой бүтцээр хангагдсан байдал	22
Цагдаагийн албан хаагчдын сургагдсан байдал	24
Үүргээ хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн байдал	26
3.2. Гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох чиг үүргийн хэрэгжилт	28
Нэвтрэн орох ажиллагаа	33
Мэдээллийн сан ашиглалт	34
Аюулын зэргийн үнэлгээ	37
Хохирогчийг мэдээллээр хангах	40
Хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах	42
Хохирогч хүүхдийг түр хамгаалалтаар хангах	46
Хүчирхийлэл үйлдэгчид авах арга хэмжээ	47
3.3. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагааны явцад хохирогчийн аюулгүй байдлыг хангах үүргийн хэрэгжилт	49
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ	57
ТАВ. ЗӨВЛӨМЖ	60
Хууль зүй, дотоод хэргийн яаманд	60
ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛД	60
ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАРТ	62

ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн тоо, гэмтлийн зэргээр
- Хүснэгт 2. Цагдаагийн ажилтны гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар хүлээсэн чиг үүрэг
- Хүснэгт 3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн мониторингийн хамрах хүрээ
- Хүснэгт 4. Цагдаагийн байгууллага, алба хаагчийн хүлээсэн үүрэг
- Хүснэгт 5. Цагдаагийн алба хаагчийн баримталдаг чиг үүрэг

- Зураг 1. Монгол улс дахь гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн гаралт, 2010-2017 он
- Зураг 2. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон хүүхдийн тоо, 2015-2017 он
- Зураг 3. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн улмаас гэмтсэн нийт хүн амын хувь, 2015-2017 он
- Зураг 4. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг, ангилалаар
- Зураг 5. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн тоо
- Зураг 6. Гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй дуудлага, мэдээллийн тоо
- Зураг 7. Мониторинг үнэлгээнд хамрагдсан аймгууд
- Зураг 8. Улаанбаатар хотоос хамрагдсан дүүрэг, хороод
- Зураг 9. Дуудлагад хугацаа хожигдсон шалтгаан
- Зураг 10. Нэвтрэн орох ажиллагааны хэрэгжилт
- Зураг 11. Аюулын зэргийн үнэлгээний хэрэгжилт
- Зураг 12. Хохирогчид зориулсан мэдээллийн хуудас
- Зураг 13. Авсан арга хэмжээ, хохирогчийн тоогоор
- Зураг 14. Аюулын зэргийн үнэлгээний дүн, эрсдлийн зэргээр
- Зураг 15. Түр хамгаалалтаар хангагдсан хүүхдийн тоо, хамгаалалтад авагдсан газраар, 2018 он
- Зураг 16. Цагдаагийн албан хаагчийн шаардлага
- Зураг 17. Зөрчлийн улмаас шийтгэл хүлээсэн байдал
- Зураг 18. Хүчирхийлэл үйлдэгчид оногдуулсан шийтгэл
- Зураг 19. Гэмт хэрэгт өртсөн гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн хүчирхийлэл дарамтад байсан хугацаа (жилээр)

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ГБХТТХ	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
НХХЯ	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НЭМ	Нийгмийн эрүүл мэнд
ТББ	Төрийн бус байгууллага
УЕПГ	Улсын ерөнхий прокурорын газар
ХЗДХ	Хууль зүй дотоод хэрэг
ХСИС	Хууль сахиулахын их сургууль
ХНХ	Хөдөлмөр нийгмийн хамгаалал
ХЭҮТ	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ЭМ	Эрүүл мэнд
ЭХХШТХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

МОНИТОРИНГИЙН БАГ

Хэрэгжүүлэгч байгууллага:

Хүчирхийллийн эсрэг үндэсний төв ТББ

Мэдээлэл нэгтгэж, тайлан бичсэн:

Ц.Алтанцэцэг, Отгонтэнгэр их сургуулийн хууль зүйн дээд сургуулийн захирал

Н.Арвинтараа, ХЭҮТ-ийн эрх зүйн шинэчлэл хөтөлбөрийн зохицуулагч, хуульч, өмгөөлөгч

С.Байгалмаа, ХЭҮТ-ийн хөтөлбөрийн менежер, хуульч

Мэдээлэл цуглуулсан мониторингийн багийн гишүүд:

М.Ариунаа, Отгонтэнгэр их сургуулийн хууль зүйн дээд сургуулийн клиник төвийн ахлагч

Ц.Баярмаа, ХЭҮТ-ийн нийгмийн ажилтан

Ц.Баярмаа, ХЭҮТ-ийн Баянхонгор аймаг дахь салбарын НЦҮТ-ийн хуульч, өмгөөлөгч

Э.Буяндэлгэр, ХЭҮТ-ийн Дундговь аймаг дахь салбарын зохицуулагч

Б.Бямбасүрэн, ХЭҮТ-ийн Завхан аймаг дахь салбарын зохицуулагч

М.Ичинхорлоо, ХЭҮТ-ийн Өвөрхангай аймаг дахь салбарын нийгмийн ажилтан

О.Нямбаяр, ХЭҮТ-ийн эмэгтэйчүүдийн түр хамгаалах байрны нийгмийн ажилтан

Ч.Одончимэг, ХЭҮТ-ийн хуулийн зөвлөгч

З.Ундрах, ХЭҮТ-ийн “Хамгаалах байруудын сүлжээ” хөтөлбөрийн зохицуулагч

Б.Сүндэрмаа, ХЭҮТ-ийн Дархан-уул аймаг дахь салбарын зохицуулагч

Г.Түвшинжаргал, ХЭҮТ-ийн сэтгэл зүйч

Д.Эрдэнэбаясгалан, ХЭҮК-ийн Хэнтий аймаг дахь салбарын ахлах мэргэжилтэн

Э.Энхцэцэг, Өмнөговь аймгийн Насан туршийн боловсрол төвийн багш

Отгонтэнгэр Их сургууль, Хууль зүйн Их сургууль, Клиник төвийн оюутнуудын баг

Орчуулсан:

Х.Нуржан

Хянан тохиолдуулсан:

Б.Сувд, НЭМ-ийн магистр, Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн тэргүүн

Хаяг:

Хүчирхийллийн эсрэг үндэсний төв ТББ, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу, 40-р байр 03, 06 тоот

И-мэйл: mongolcav@gmail.com

Вэб сайт: www.safefuture.mn

НЭГ. ОРШИЛ

1.1. Эрх зүйн орчин

Монгол Улс Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг 2004 онд батлан хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 12 жилийн туршлага, сургамжиндаа үндэслэн 2016 онд тус хуулийг бүхэлд нь шинэчлэн баталсан.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 2017 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхлээд 1 жил 10 сарын хугацаа өнгөрч байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчлэлд хамаарах зарчмын томоохон өөрчлөлтийн нэг нь хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх процессыг тодруулснаас гадна гэр бүлийн хүчирхийллийг иргэний эрх зүйн маргаан бус гэмт хэрэг, зөрчил болохыг хуульчилсан явдал билээ.

Хууль хэрэгжиж эхлээд харьцангуй богино хугацаа өнгөрч байгаа хэдий ч хохирогчид үйлчилгээ үзүүлэх, хамгаалалтаар хангах нэгж буюу хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн тоо нэмэгдсэн, үүрэг хүлээсэн мэргэжилтнүүдийг сургах, бэлтгэх ажил эрчимжсэн, гэр бүлийн хүчирхийллийн асуудал хариуцсан тусгай нэгжийг Цагдаагийн ерөнхий газар болон Нийслэлийн цагдаагийн газарт байгуулсан, аймаг, дүүргийн цагдаагийн газарт гэр бүлийн хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан цагдаагийн ажилтны орон тоог бий болгосон зэрэг олон бодит ахиц гарсан байна.

Мөн хуулиар гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдээллийн санг салбар бүрийн оролцоотой бүрдүүлж, дүн шинжилгээнд үндэслэн хүчирхийлэлтэй тэмцэх бодлого, арга зүйг боловсруулах, төсөв, хүний нөөцийн хуваарилалтыг төлөвлөх эрх зүйн үндсийг тогтоосон. Түүнчлэн хохирогч, хүчирхийлэл үйлдэгчийн талаарх мэдээллийн санг бүрдүүлж, анхан шатны нэгжийн үйл ажиллагаанд ашиглах боломж бүрдсэн.

Үүний дагуу Үндэсний статистикийн хороо болон хууль хэрэгжүүлэгч байгууллагууд бүртгэл, тайландаа гэр бүлийн хүчирхийллийн гаралт, түүнээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлд хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх тодорхой мэдээллийг тусгах болжээ.


Цагдаагийн байгууллага нь 2015 оноос гэр бүлийн хүчирхийллийн улмаас

Үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийг тусгайлан гаргаж эхэлсэн бөгөөд 2018 оноос Мэдээлэл, шуурхай удирдлагын төв буюу 102 дугаарын утсанд ирсэн мэдээллийн бүртгэлд гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой дуудлага, мэдээлэл, түүний дагуу авсан арга хэмжээг нарийвчлан тусгах болсон байна.¹

1.2. Гэр бүлийн хүчирхийллийн өнөөгийн байдал

Цагдаагийн байгууллагын статистик мэдээллээс үзэхэд гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн гаралт 2016 оныг хүртэл жил дараалан өсч ирсэн бол 2017 онд 163 хэргээр буурсан байна.

2018 оны эхний 9 сарын байдлыг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл 5 хэргээр буюу 0.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.




Зураг 1. Монгол улс дахь гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн гаралт, 2010-2017 он

Гэвч тус гэмт хэргийн улмаас 2015 онд **66**, 2016 онд **69** хүүхэд хохирогчоор тогтоогдсон бол 2017 онд насанд хүрээгүй хохирогчийн тоо **90** болж нэмэгдсэн байна.² Ийнхүү 2015-2017 онд гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн улмаас нийт 225 хүүхдийн эрх зөрчигдөж хохирогч болжээ. Дээрх онуудад гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэгт өртсөн нийт хохирогч хүүхдийн 132 нь бага насны хүүхэд байсан бөгөөд 2015 онд хохирсон хүүхдийн **65%** хувь, 2016 онд **53.6%**, 2017 онд хохирогч хүүхдийн **57.7%** нь 14-өөс доош насны хүүхэд байна.

1 Цагдаагийн байгууллагын статистик мэдээлэл. <https://www.police.gov.mn>

2 Цагдаагийн байгууллагын 2015, 2016, 2017 оны гэмт хэргийн статистик мэдээлэл.




Зураг 2. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон хүүхдийн тоо, 2015-2017

Мөн 2015 онд гэр бүлийн хүчирхийллийн улмаас 24 хүн амь насаа алдаж, 1154 хүн гэмтэл авсан бол 2016 онд 16 хүн амь насаа алдаж, 936 хүн гэмтсэн, 2017 онд 9 хүн амь насаа алдаж, 1184 хүн гэмтсэн байна.

Хүснэгт 1. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн тоо, гэмтлийн зэргээр

	Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг		Гэмтлийн зэрэг		
	Нийт	Гэмтсэн хүн тоо, %	Хөнгөн тоо, %	Хүндэвтэр тоо, %	Хүнд тоо, %
2015 он	1356	1154, 85.1	1060, 91.9	60, 5.2	34, 2.9
2016 он	1449	1217, 84.0	1145, 94.1	52, 4.3	20, 1.6
2017 он	1286	936, 72.8	881, 94.1	32, 3.4	23, 2.5


Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн улмаас хохирогчдын 70-аас дээш хувь нь гэмтэл, бэртэл авдаг байна. Тухайлбал: 2015 онд гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн 85.1 хувь нь гэмтсэн байгаагийн 5.2 хувь нь хүндэвтэр, 2.9 хувь нь хүнд гэмтжээ. 2016 болон 2017 онуудад нийт гэмтсэн хүн амын 5.9 хувь нь хүндэвтэр болон хүнд зэргийн гэмтэл авсан байна (Хүснэгт 1, Зураг 3).



Эх сурвалж: ЦЕГ-ын статистик мэдээ, 2015-2017 он

Зураг 3. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн улмаас гэмтсэн нийт хүн амын хувь, 2015-2017 он

2015 онд бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн 77.8% нь хөнгөн, 13.6% нь хүндэвтэр, 5.8% нь хүнд, 2.8% нь онц хүнд гэмт хэрэг байсан бол 2016 онд үйлдэгдсэн гэмт хэргийн 83% нь хөнгөн, 11.4% нь хүндэвтэр, 3.5% нь хүнд, 2.1% нь онц хүнд гэмт хэрэг, 2017 онд үйлдэгдсэн гэмт хэргийн 86.9% нь хөнгөн, 6.4% нь хүндэвтэр, 5.1% нь хүнд, 1.7% нь хөнгөн гэмт хэрэг байна.³



Зураг 4. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг, ангилалаар

Үндэсний статистикийн хорооноос жил бүр гаргадаг Гэмт хэргийн статистикийн мэдээлэлд⁴ 2017 онд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хөнгөн гэмт хэрэг өмнөх оноос 3.9 пункт, хүнд хэлбэрийн

³ Статистикийн үндэсний хорооны мэдээлэл. 2017 он. <https://www.nso.mn/>

⁴ Гэмт хэргийн статистик үзүүлэлт-2017 он. Монгол Улсын Үндэсний статистикийн хороо

хүчирхийлэл 1.6 пунктээр нэмэгдэж, харин хүндэвтэр хэрэг 5.0 пункт, онц хүнд хэрэг 0.4 пунктээр буурчээ.

Хүндэвтэр болон онц хүнд хэлбэрийн хүчирхийлэл буурсан нь Монгол Улсад Эрүүгийн хуулийн шинэчлэлээр⁵ гэмт хэргийг хөнгөн, хүнд гэж хоёр ангилдаг болсонтой холбоотой өөрчлөлт юм”.

Цагдаагийн байгууллагын статистик мэдээллээс сүүлийн жилд гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэрэг тодорхой хувиар буурсан боловч гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн зөрчлийн тоо тогтмол өсөлттэй байна.




Зураг 5. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн тоо

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас 2016 онд 1886 зөрчил бүртгэгдэж байсан бол 2017 онд **2.4 дахин** өссөн байна. 2018 оны эхний 10 сарын байдлаар 4794 гэр бүлийн хүчирхийллийн зөрчил бүртгэгджээ.⁶

Цагдаагийн байгууллага 2016 онд 15842, 2017 онд 31853, 2018 оны эхний 10 сарын байдлаар 32878 гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй дуудлага, мэдээлэл хүлээн авчээ. Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээлэл 2017 онд өмнөх оноос 2 дахин нэмэгдсэн байна.

⁵ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш 1 жил 5 сарын дараа шинээр батлагдсан Эрүүгийн эрх зүйн багц хууль үйлчилж эхэлсэн.

⁶ Цагдаагийн байгууллагын статистик мэдээлэл. <https://www.police.gov.mn>



Эх сурвалж: ЦЕГ-ын статистик мэдээ

Зураг 6. Гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй дуудлага, мэдээллийн тоо

Харин 2016 онд гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн 3335 тохиолдол бүртгэгдсэн бол 2017 онд 5655 болж 69%-иар өссөн байна.

Дээрх статистик мэдээллээс дүгнэхэд иргэдээс гэр бүлийн хүчирхийллийн талаар цагдаагийн байгууллагад мэдээлэгдэх байдал нэмэгдсэн байна. Хэдийгээр гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг буурсан үзүүлэлттэй боловч хүний амь нас эрсэдсэн, хүний эрүүл мэндэд хохирол учирсан тохиолдол буураагүй, хүүхэд хохирсон хэргийн эзлэх хувь өссөн байна.

Гэмт хэрэг буурсан боловч ноцтой тохиолдлын давтамж буураагүй, зарим талаар өсөлттэй байна. Хэдийгээр хөнгөн гэмт хэргийн гаралт буурсан боловч зөрчлийн тоо 2 дахин нэмэгдсэнийг гэр бүлийн хүчирхийллийн гаралт буурсан биш, хуулийн зохицуулалтын өөрчлөлт нөлөөлсөн гэж дүгнэхээр байна.

Хууль хэрэгжилтийн практик хэвшин тогтож байгаа энэ цаг үед хохирогчдод тусламж, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий мэргэжилтнүүдийн (цагдаагийн алба хаагч, нийгмийн ажилтан, өрхийн эмч, багш, сум, багийн Засаг дарга гэх мэт) үүргийн хэрэгжилтийн бодит байдлыг үнэлэх замаар сайн туршлага, тулгарч буй бэрхшээлийг нээн илрүүлж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг бодитой төлөвлөх нь чухал билээ.

Дэлхийн олон оронд иргэний нийгмийн байгууллагууд нь мониторингийн аргыг хүний эрхийн зөрчил, авилга, хүнд суртал гэх мэт төрийн бодлого,

үйл ажиллагааны янз бүрийн гажуудалтай тэмцэн хариуцлага тооцох нөлөөллийн хэрэгсэл болгон түгээмэл хэрэглэсээр ирсэн.

Төрийн үйлчилгээнд хөндлөнгийн хяналт тавих замаар аливаа хууль тогтоомжийг практикт жинхэнэ утгаар хэрэгждэг болох, сайн засаглал бүрэлдэн хөгжихөд хувь нэмрээ оруулах нь иргэний нийгмийн байгууллагын чухал үүрэг билээ.

Иймээс бид энэ удаагийн мониторингийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар цагдаагийн алба хаагчийн хүлээсэн үүргийн хэрэгжилтийн байдлыг үнэлэхэд чиглүүлсэн болно.

Мониторингийн зорилго

Мониторинг нь гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, түүний гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдал бодит амьдрал дээр хамгаалагдаж чадаж байгаа эсэх, цагдаагийн байгууллага, алба хаагчдын хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг илрүүлж, цаашид хуулийн хэрэгжилтийг сайжруулах зөвлөмж боловсруулах үндсэн зорилготой юм. Энэхүү зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараахь зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

1. ГБХТ тухай хуулиар цагдаагийн байгууллага, алба хаагчийн хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийн өнөөгийн байдлыг тогтоох;
2. Хууль, журам, процедурын хийдэл цоорхойг илрүүлэн зохицуулалт, арга механизмыг боловсронгуй болгох нөхцөл, аргачлалыг эрэлхийлэх;
3. Мониторингийн дүнд үндэслэн санал, зөвлөмж боловсруулж улмаар хууль хэрэгжилтийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэхэд чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах.

ХОЁР. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН ҮҮРЭГТ МОНИТОРИНГ ХИЙСЭН АРГАЗҮЙ

Энэхүү мониторинг нь мэдээллийн, тоон, чанарын, ажиглалтын, туршилтын аргуудыг ашиглан хийгдсэн.

Цагдаагийн байгууллага, алба хаагчаас болон гэр бүлийн хүчирхийллийн дуудлагатай холбоотой мэдээллийг тусгайлан бэлтгэгдсэн мэдээлэл цуглуулагчид шууд оролцож чанарын аргаар олж авсан анхдагч мэдээлэл, энэ чиглэлээр өмнө хийгдэж байсан судалгаа, бодлогын баримт бичигт анализ хийсэн хоёрдогч мэдээлэлд үндэслэн цуглуулсан.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар цагдаагийн алба хаагч нь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийг илрүүлэх, дуудлага, мэдээллийг хүлээн авах, хүчирхийллийг таслан зогсоох, хохирогч, түүний гэр бүлийн гишүүдийг хамгаалалтаар хангах, тусламж, үйлчилгээнд холбох, хүчирхийллийн бодит байдлыг баримтжуулах, гэмт хэрэг, зөрчлийг шалгах, хүчирхийлэл үйлдэгчид хяналт тогтоох арга хэмжээг хэрэгжүүлэх өргөн хэмжээний үүргийг хүлээдэг (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Цагдаагийн ажилтны гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар хүлээсэн чиг үүрэг

Чиг үүрэг		Үүрэг	ГБХТХ-ийн зохицуулалт
1	Урьдчилан сэргийлэх	Хамтарсан багийн гишүүнээр ажиллах	20 дугаар зүйл
		Мэдээллийн сан бүрдүүлэх	25 дугаар зүйлийн 25.1.1
		Иргэдэд мэдээлэл түгээх	20.2.1 дэх заалт
2	Хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох	Гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх	23, 24 дүгээр зүйл
		Гомдол, мэдээлэл хүлээн авах	23 дугаар зүйл
		Хэргийн газарт очих, таслан зогсоох	25 дугаар зүйлийн 25.4 дахь хэсэг
		Хохирогчийн аюулгүй байдлыг шалгах	25 дугаар зүйлийн 25.4 дахь хэсэг
3	Хохирогч, түүний гэр бүлийн гишүүдийн	Хохирогч, гэр бүлийн бусад гишүүдийн аюулгүй байдлыг хангах	25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсэг, 30, 31 дүгээр зүйл

	аюулгүй байдлыг хангах	Үйлчилгээнд холбон зуучлах	33 дугаар зүйл.
		Хүчирхийлэл үйлдэгчид шаардлага тавих, баривчлах, эрүүлжүүлэх	25 дугаар зүйлийн 25.4.2, 25.4.6, 25.6, 25.7 дахь хэсэг
		Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн аюулгүй байдлыг хамгаалах	35 дугаар зүйлийн 35.3, 35.6 дахь хэсэг
		Хохирогчхүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулах үед аюулгүй байдлыг хамгаалах	43 дугаар зүйлийн 43.6 дахь хэсэг
4	Гэмт хэрэг, зөрчлийг шалган тогтоох ажиллагааны явцад хохирогчийн аюулгүй байдлыг хангах		8 дугаар зүйл
5	Хүчирхийлэл үйлэгчид хяналт тавих	Баривчлах шийтгэл эдэлж байгаа этгээдийг зан үйлд нөлөөлөх албадан сургалтанд хамруулах	44 дүгээр зүйлийн 44.4 дэх хэсэг

Өөрөөр хэлбэл, цагдаагийн байгууллага нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тогтолцоонд голлох үүргийг хэрэгжүүлдэг төдийгүй хүчирхийллийн тодорхой тохиолдлыг илрүүлэх, таслан зогсоохоос эхлээд хэрэг, зөрчлийг шийдвэрлэгдэж дуусах хүртэлх бүхий л үе шатанд оролцдог.

Иймд цагдаагийн алба хаагчийн үүргийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиас гадна Цагдаагийн албаны тухай⁷, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай⁸, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай⁹, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай¹⁰, Зөрчил шалган шийдвэрлэх тухай¹¹, Хүүхэд хамгааллын тухай¹² хуулиудын холбогдох заалтаар тус тус зохицуулж байна.

Цагдаагийн алба хаагч хуулиар хүлээлгэсэн үүргээ хэрэгжүүлэхдээ холбогдох журам болон Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан тусгай стандартыг мөрдөн ажилладаг.

7 Цагдаагийн албаны тухай хууль. 2017 он. [https:// www.legalinfo.mn](https://www.legalinfo.mn)

8 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль. 1997 он. [https:// www.legalinfo.mn](https://www.legalinfo.mn)

9 Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль. 2013 он. [https:// www.legalinfo.mn](https://www.legalinfo.mn)

10 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. 2017 он. [https:// www.legalinfo.mn](https://www.legalinfo.mn)

11 Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль. 2017 он. [https:// www.legalinfo.mn](https://www.legalinfo.mn)

12 Хүүхэд хамгааллын тухай хууль. 2016 он. [https:// www.legalinfo.mn](https://www.legalinfo.mn)

Тухайлбал, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/263 тушаалаар Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх журмыг шинэчлэн баталсан бөгөөд тус журамд урьдчилан сэргийлэх шатнаас эхлээд,

- ▲ гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээллийг хүлээн авах;
- ▲ таслан зогсоох;
- ▲ хохирогчийг хамгаалалтаар хангах;
- ▲ шаардлагатай үйлчилгээнд холбох;
- ▲ гэмт хэрэг, зөрчлийг шалган тогтоох бүхий л үе шатанд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд мөрдөн ажиллах стандартыг тогтоосон байна.

ЦЕГ-ын даргын тушаалаар баталсан Мэдээлэл, шуурхай удирдлагын албаны үйл ажиллагааны журмаар¹³ гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдээлэл хүлээн авахад анхаарах зүйл, заавал тодруулах шаардлагатай нөхцөл байдлыг заасан бол Хүүхдийн эрхийг хангах¹⁴, Бэлэгсийн гэмт хэргийн насанд хүрээгүй хохирогчийн талаар авах арга хэмжээ¹⁵, Гэрч хохирогчийг хамгаалах¹⁶, Судалгаа, хяналтын тоо бүртгэл хөтлөх¹⁷, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх¹⁸ үйл ажиллагааг хэрэгжүүлэх стандартад мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах, хохирогчийн онцлог хэрэгцээг харгалзан тусгай хамгаалалтаар хангах зохицуулалтыг тусгасан байна.

Түүнчлэн цагдаагийн алба хаагчийн ажлын байрны тодорхойлолт, тодорхой чиглэлийн алба, нэгжийн үйл ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлтэд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр гүйцэтгэх ажил үүрэг, түүний үр дүнг тооцох нөхцөлийг тусгажээ.

Ийнхүү цагдаагийн алба хаагчийн гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлд хүлээх үүргийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой баталсан журмаас гадна дээр дурьдсан хуулиуд, мөн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд баримтлах стандартаар нарийвчлан журамласан байна.

Гэхдээ эдгээр хууль, дүрэм журмын зохицуулалтын үр дүн нь бодит байдалд хохирогч хамгаалалтаар хангагдаж чадаж байгаа эсэх, энэхүү

13 Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/262 дугаар тушаал.

14 Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/263 дугаар тушаал.

15 Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/263 дугаар тушаал.

16 Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/265 дугаар тушаал.

17 Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/265 дугаар тушаал.

18 Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/262 дугаар тушаал.

хамгаалалт нь шуурхай бөгөөд хохирогчийн эрх ашигт нийцсэн эсэхээс шууд хамаарна.

Иймд энэхүү үнэлгээний хүрээнд цагдаагийн алба хаагчдын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд практикт тулгарч буй асуудлыг илрүүлэх, хуулийн хэм хэмжээг хэрэгжүүлэхэд аль шатанд гажуудал үүсээд байгаагийн шалтгааныг тогтоох, хуулийн хэрэгжилтийг сайжруулахад нөлөөлөх, тулгамдсан асуудлыг хамтран шийдвэрлэх арга замыг тодорхойлоно.

Мониторингийн судалгааны хамарсан хүрээ:


- Гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх;
- Гомдол, мэдээлэл хүлээн авах;
- Хүчирхийллийг таслан зогсоох ажиллагаа;
- Хохирогчийн аюулгүй байдлыг хангах ажиллагаа;
- Хохирогч хүүхдийг хамгаалалтаар хангах;
- Хохирогчид үйлчилгээ үзүүлэх явцад аюулгүй байдлыг хангах;
- Зөрчил шалгах, шийдвэрлэх ажиллагааны явцад хохирогчийн аюулгүй байдлыг хангах;
- Гэмт хэрэг шалгах ажиллагааны явцад хохирогчийн аюулгүй байдлыг хангах

гэсэн 8 хүрээгээр Хэнтий аймгийн Хэрлэн сум, Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 6, 11 дүгээр баг, Дундговь, Өмнөговь, Дархан-Уул, Баянхонгор, Завхан аймаг зэрэг 7 аймаг, УБ хотын 6 дүүргийн 14 хороог хамруулан гүйцэтгэсэн.



Зураг 7. Мониторинг үнэлгээнд хамрагдсан аймгууд

Улаанбаатар хотын БЗД-ийн 12, 26 дугаар хороо, СХД-ийн 7, 9, 10, 12, 22, 25 дугаар хороо, СБД-ийн 15 дугаар хороо, ХУД-ийн 1 дүгээр хороо, ЧД-ийн 16,18 дугаар хороо, БГД-ийн 2, 11 дүгээр хороог хамруулан гүйцэтгэсэн.



Зураг 8. Улаанбаатар хотоос хамрагдсан дүүрэг, хороод

Судалгааг урьдчилан боловсруулсан удирдамжийн дагуу 2018 оны 6-р сарын 1-нээс 2018 оны 10 дугаар сарын 31-нийг хүртэл 5 сарын хугацаанд асуумж бөглөх, ажиглалт хийх, ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага хийх, баримт мэдээллийн, тоон, чанарын, ажиглалтын, туршилтын, түлхүүр үгээр мэдээлэл хайх аргуудыг ашиглан явуулсан.

Үнэлгээнд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн дараах зүйл, заалтын хэрэгжилтийг хамрууллаа:

Хүснэгт 3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн мониторингийн хамрах хүрээ

Чиг үүргийн ангилал		Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
1	Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх	11 дүгээр зүйлийн 11.1.4, 11.1.5, 11.1.6 дахь заалт
2	Хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох	23, 25 дугаар зүйлийн 25.4, 25.5, 25.6 дахь хэсэг
3	Хохирогчийн аюулгүй байдлыг хангах	30, 31, 34 дүгээр зүйл

Мөн цагдаагийн алба хаагчийн үүргийг хэрэгжүүлэх журмыг Цагдаагийн албаны тухай хуулийн холбогдох заалтаар зохицуулсан байх тул энэхүү үнэлгээний хүрээнд Цагдаагийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.5, 11.1.7 дахь заалт, 23 дугаар зүйлийн 23.1, 23.7 дахь хэсэг, 28, 46 дугаар зүйл болон хуулийг хэрэгжүүлэх хүрээнд батлагдсан холбогдох журам, стандартын хэрэгжилтийн байдлыг давхар авч үзсэн.

ГУРАВ. ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

Мониторингийн үр дүнг (i) гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үүргийн хэрэгжилт, (ii) гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох чиг үүргийн хэрэгжилт (iii) гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагааны явцад хохирогчийн аюулгүй байдлыг хангах үүргийн хэрэгжилт гэсэн 3 дэд бүлгээр тайлагналаа.

3.1. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үүргийн хэрэгжилт

Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хүрээнд цагдаагийн байгууллага, алба хаагч нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4, 11.1.5, 11.1.6 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1.1, 25.1.2 дахь заалт, мөн зүйлийн 25.2, 25.3 дахь хэсгээс гадна Цагдаагийн албаны тухай хуулийн¹⁹ 17 дугаар зүйлийн 17.2, 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь хэсэг, 71 дүгээр зүйлд заасан тодорхой үүргийг хүлээсэн байна.


Хүснэгт 4. Цагдаагийн байгууллага, алба хаагчийн хүлээсэн үүрэг

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль	Цагдаагийн албаны тухай хууль
<p>11 дүгээр зүйл. Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг</p> <p>11.1.4. Гэр бүлийн хүчирхийллийн талаархи статистик мэдээлэл, тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх журам, хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэх болон холбогдох бусад байгууллага хоорондын мэдээлэл солилцох журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн баталж, хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>11.1.5. Хууль сахиулагчийг бэлтгэх сургалтын хөтөлбөр, стандартад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль тогтоомжийг хэрэглэх үр чадвар эзэмшүүлэх агуулгыг тусгах;</p> <p>11.1.6. Харьяа агентлаг, байгууллагын ажилтны ажлын байрны тодорхойлолтод энэ хуульд заасан чиг үүргийг тусгасан байдалд хяналт тавих;</p>	<p>17 дугаар зүйл. Цагдаагийн албаны сургалтын байгууллага</p> <p>17.2. Мэргэжлийн бэлтгэл, давтан болон албаны сургалт явуулах журмыг цагдаагийн төв байгууллагын дарга батална.</p> <p>71 дүгээр зүйл. Ажлын байрны тодорхойлолт</p> <p>71.1. Цагдаагийн алба хаагчийн гүйцэтгэх чиг үүргийг ажлын байр /албан тушаал/-ын тодорхойлолтоор тогтоох бөгөөд уг тодорхойлолтыг цагдаагийн төв байгууллагын дарга батална.</p>

¹⁹ www.legalinfo.mn

<p>20 дугаар зүйл. Хамтарсан баг</p> <p>20.1. Хамтарсан баг нь өрхийн эмч, сум, хороо, сургуулийн, халамжийн, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн нийгмийн ажилтан, цагдаагийн алба хаагч, энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдэх бөгөөд хамтарсан багийг тухайн сум, хорооны Засаг дарга ахална.</p> <p>25 дугаар зүйл. Цагдаагийн байгууллага, алба хаагчийн үүрэг</p> <p>25.1. Цагдаагийн байгууллага нь Цагдаагийн албаны тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд зааснаас гадна гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх талаар дараахь үүргийг хүлээнэ:</p> <p>25.1.1. Хүчирхийлэл үйлдэгч, хохирогчийн талаархи бүртгэл хөтлөх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, ашиглах;</p> <p>25.1.2. Энэ хуулийн 23 дугаар зүйлд заасан мэдээллийг хүлээн авч, шаардлагатай тусламж, зөвлөгөө өгөх, холбон зуучлах утас 24 цагаар ажиллуулах.</p> <p>25.2. Тухайн орон нутгийн хүн амын тоо, эрүүгийн болон нийгмийн хэв журмын нөхцөл байдлыг харгалзан цагдаагийн байгууллагын бүтцэд цагдаагийн мэргэшсэн алба хаагчдаас бүрдсэн нэгжтэй байж болно.</p>	<p>21 дүгээр зүйл. Цагдаагийн төв байгууллагын даргын бүрэн эрх</p> <p>21.1.3. Цагдаагийн байгууллагын дотоод албаны дүрэм, цагдаагийн хүрээний болон эргүүл, харуулын дүрэм, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөх бусад дүрэм, журам, зааврыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, биелэлтийг хангуулах;</p>
---	--

Цагдаагийн алба хаагч нь хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхийн тулд тодорхой мэдлэг, мэдээлэлтэй, мэргэшсэн байх, зайлшгүй шаардлагатай хэрэглэгдэхүүн, техник, тоног төхөөрөмж, арга зүйгээр хангагдсан байх шаардлагатай.



Өөрөөр хэлбэл, цагдаагийн алба хаагчийн үүргийн хэрэгжилт нь дан ганц өөрөөс нь бус цагдаагийн байгууллагын зохион байгуулалт, алба хаагчиддаа үзүүлж буй мэргэжил арга зүй, техникийн хангалт болон хамтран ажиллах бусад салбарын мэргэжилтнүүдийн хамтын ажиллагаанаас давхар хамаарна.

Иймд цагдаагийн албан хаагчид гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиг үүргээ хэрэгжүүлэхэд зохион байгуулалт, бэлтгэгдсэн байдал, техникийн хангалтад хийсэн дүнг танилцуулъя.

Зохион байгуулалтын зохистой бүтцээр хангагдсан байдал

2017 оноос Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд батлагдсан багц хуулиуд болон Цагдаагийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор цагдаагийн байгууллагад нилээд шинэчлэлтүүд хийгджээ.

ЦЕГ-ын даргын 2017 оны Б/42 дугаар тушаалаар “Гэр бүлийн хүчирхийлэлтэй, тэмцэх урьдчилан сэргийлэх хэлтэс”-ийг Мэдээлэл нэгтгэн боловсруулах газарт байгуулсан бөгөөд 2014 оноос хойш Нийслэлийн цагдаагийн газрын харьяанд 30 ор бүхий түр хамгаалах байрыг ажиллуулж байна.

Мөн Гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох, хохирогчдод цаг алдалгүй яаралтай тусламж үзүүлэх, мэдээлэл өгөх зорилго бүхий “107” тусгай дугаарын 24 цагийн утсыг ажиллуулж хэвшжээ.

2017 оноос аймаг, дүүргийн цагдаагийн газар, хэлтэст гэр бүлийн хүчирхийллийн асуудал хариуцсан мэргэжилтний орон тоог бий болгож, өнөөдрийн байдлаар 60 орчим мэргэжилтэн ажиллаж байна.

Ийнхүү цагдаагийн байгууллагаас хохирогчид хамгаалалт, үйлчилгээ үзүүлэх тусгай нэгж болон үүрэг хүлээсэн алба хаагчдыг мэргэжил, арга зүйгээр хангах бүтэц, зохион байгуулалтыг хийж эхэлсэн нь сайшаалтай байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-т “Тухайн орон нутгийн хүн амын тоо, эрүүгийн болон нийгмийн хэв журмын нөхцөл байдлыг харгалзан цагдаагийн байгууллагын бүтцэд цагдаагийн мэргэшсэн алба хаагчдаас бүрдсэн нэгжтэй байж болно.” гэж заасан боловч 2015 онд Нийслэлийн цагдаагийн газарт байгуулагдсан 1 хэлтсээс өөр мэргэшсэн нэгж орон нутагт байгуулагдаагүй байна.

Мөн “1 хэсгийн байцаагч 4 000 хүн ам тутамд, хэв журмын эргүүл нийслэлд

21 “Цагдаагийн байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай”, Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан

15 000 хүн ам тутамд хоёроос доошгүй, аймгийн төвд 5 000 хүн ам тутамд нэгээс доошгүй, эргүүлийн нэг чиглэлд хоёр албан хаагч үүрэг гүйцэтгэх” талаар зохицуулсан “Цагдаагийн байгууллагын зарим ажил, үйлчилгээ, хангалтын жишиг норматив” хэрэгжихгүй байна.

Өнөөдөр цагдаагийн байгууллагад 4585 орон тоо шаардлагатай гэсэн тооцоо судалгаа байдаг. Гэвч сүүлийн 4-5 жилд орон тооны өөрчлөлт хийгдээгүй. Бид одоогийн нөхцөл байдал, ажлын ачаалалдаа тохируулан байгаа орон тоо, хүн хүчээ дотооддоо шилжүүлэх, сэлгэж ажиллуулах замаар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

*Эх сурвалж: “Өнөөдөр сонин”
ЦЕГ-ын Захиргааны удирдлагын газрын дарга,
цагдаагийн хурандаа Б.Бат-Өлзийн ярилцлагаас*

ГБХ-ийн асуудлыг шийдвэрлэхэд хугацаа их ордог тул дуудлага хүлээн авах, дуудлагаар ажиллах, хүлээн авах бие бүрэлдэхүүнийг нэмэх шаардлагатай байдаг.

Цагдаагийн алба хаагчтай хийсэн ярилцлага

2017 оны гэмт хэргийн статистик бүртгэлээс үзэхэд Өвөрхангай, Говьсүмбэр, Сүхбаатар аймагт болон Нийслэлийн Баянзүрх, Хан-Уул, Налайх дүүрэгт гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн гаралт нэмэгдсэн бол Баян-Өлгий, Хөвсгөл, Сэлэнгэ, Төв аймгуудад энэ төрлийн гэмт хэргийн гаралт төдийлөн буурахгүй, Хөвсгөл, Сэлэнгэ аймгуудад онц хүнд гэмт хэргийн гаралт өндөр хэвээр байна.²²

Энэ чиглэлд хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд ажиллах орчин, санхүүгийн нөхцөл байдал хүндрэлтэй байдаг. Алслагдсан сум, орон нутагт зардлыг хохирогчоос өөрөөс нь гаргуулж байгаа нь тухайн хүндээ бэрхшээлтэй.

Орон нутагт хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв, баривчлах байр байхгүй учраас зарим үед хохирогчийг гэртээ хүртэл аваачиж хонуулах тохиолдол гардаг. Эргээд элдэв байдлаар дарамтлуулах,

22 Гэмт хэргийн статистик үзүүлэлт-2017 он. Монгол Улсын Үндэсний статистикийн хороо

хардуулах гээд олон асуудалд ордог. Цагдаагийн алба хаагчдын амь насыг хамгаалах талаар арга хэмжээ чухал байна.

Цагдаагийн алба хаагчтай хийсэн ярилцлага

Үүнээс дүгнэхэд цагдаагийн байгууллага нь хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд нийтлэг стандартаар бус нутаг дэвсгэр, хүн амын тоо, гэр бүлийн хүчирхийллийн тархацын байдлаас хамаарч хүн хүч, нөөцийн зохистой хуваарилалтыг хийх зэргээр уян хатан нөхцөлийг ханган ажиллах шаардлагатай байна.

Цагдаагийн албан хаагчдын сургагдсан байдал

Цагдаагийн алба хаагчийн ажлын байрны тодорхойлолтод гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиг үүргийг тусгаж, энэхүү чиг үүргийн хэрэгжилт нь түүний мэргэшлийн ур чадвар, ажлын гүйцэтгэлийг үнэлэх, хариуцлага тооцох шалгуур төдийгүй давтан сургах, мэргэшүүлэх үндэслэл болно.

Түүнчлэн цагдаагийн алба хаагчдыг бэлтгэх албан хөтөлбөрт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиг үүргээ хэрэгжүүлэх ур чадвар олгох агуулга, арга зүй тусгаж, хөтөлбөрийн дагуу сургалтад хамруулж, бэлтгэсэн байх шаардлага тавигдаж байна.

Цагдаагийн ерөнхий газрын мэдээллээр хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газраас давхардсан тоогоор 12.500 гаруй цагдаагийн алба хаагчийг сургалтанд хамруулжээ.²³

ЦЕГ-ын Урьдчилан сэргийлэх хэлтэс 2017 онд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, түүнийг даган батлагдсан журмуудын хэрэгжилтийг хангах, алба хаагчдыг чадавхижуулах зорилгоор 31 удаагийн сургалт зохион байгуулж 2580 цагдаагийн алба хаагч, 107 хамтарсан багийн 475 ажилтан, 591 иргэнийг хамруулжээ. Үүнээс 20 удаагийн сургалтыг Хууль зүй, дотоод хэргийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, НҮБ-ын Хүн амын сан, Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллага, Дэлхийн зөн Монгол олон

²³ Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл.

улсын байгууллага зэрэг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулжээ.

Цагдаагийн ерөнхий газар, НҮБ-ын Хүн амын сантай “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу 2018 онд алба хаагчдыг чадавхижуулах сургалтыг Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд даргын баталсан хөтөлбөр, удирдамжийн дагуу зохион байгуулсан байна.

Цагдаагийн ерөнхий газрын мэдээллээс

2017-2018 онуудад цагдаагийн алба хаагчдын тодорхой хувийг сургалтанд хамруулсан ч энэхүү сургалт нь алба хаагчдын хувьд албан ёсны буюу заавал хамрагдсан байх шаардлагад хамаарахгүй, практикт ажиллаж байгаа алба хаагчдыг энэ чиглэлд давтан сургах (ур чадвар олгох), мэргэшүүлэх ажил тасралтгүй хийгдэж чадахгүй байна.

Цагдаагийн алба хаагч бэлтгэдэг сургуулийн (ХСИС-ийн харьяа Цагдаагийн сургууль, Ахлагчийн сургууль) сургалтанд гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн онцлог, хохирогчтой ажиллах арга зүйг тусгасан агуулга бүхий хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Гэхдээ гэр бүлийн хүчирхийллийг дуудлага, мэдээллийн дагуу таслан зогсоох ажиллагааг шуурхай удирдлагын баг (102 утасны дуудлагаар ажиллах хэсэг), эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчаас гадна нутаг дэвсгэр хариуцсан хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагч хэрэгжүүлдэг²⁴ тул нэн тэргүүнд эдгээр алба хаагчдыг сургаж, дадлагажуулах нь чухал байна. Дээрх нэгж, хэсгийн алба хаагч, хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагчдын хэдэн хувь нь сургалтад хамрагдсан талаарх мэдээлэл байхгүй байна.

Цагдаагийн алба хаагчдыг бэлтгэх сургалтанд зориулж улсын болон орон нутгийн төсвөөс тодорхой зардал гаргасан талаарх тодорхой мэдээлэл байхгүй, харин дийлэнх сургалт олон улсын байгууллагын санхүүжилт, төсөл хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагджээ.

²⁴ Хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагчаас харьяалах нутаг дэвсгэрт орших хүн амд үзүүлэх хамгаалалт, үйлчилгээ нь өрх, гэр бүлд илүү чиглэсэн байдгаараа бусад цагдаагийн алба хаагчдаас (төвлөрсөн буюу цагдаагийн газар, хэлтэст ажиллаж байгаа мөрдөн байцаагч, эрүүгийн төлөөлөгч) онцлог ялгаатай байдаг.

Энэ нь алба хаагчдад зориулсан сургалт нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу, үе шаттай хийгдэхгүй байгааг харуулж байна.

Үүргээ хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн байдал

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасны дагуу цагдаагийн алба хаагч дараах журмуудыг баримтлан чиг үүргээ хэрэгжүүлж байна.

Хүснэгт 5. Цагдаагийн алба хаагчийн баримталдаг чиг үүрэг

Журам		Батлагдсан огноо, дугаар	
1	Аюулын зэргийн үнэлгээ хийх журам	2017.02.14	ХЗДХ-ийн сайдын А/37 дугаар тушаал
2	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах журам	2017.02.09	УЕП, ХЗДХ-ийн сайдын хамтарсан А/22, А/31 дүгээр тушаал
3	Хамтарсан багийн ажиллах, санхүүжүүлэх журам	2017.10.04	ХНХ, ХЗДХ, ЭМ-ийн сайдын хамтарсан А/173, А/259, А/380 дугаар тушаал
4	Мэдээллийн сан бүрдүүлэх журам	2017.01.31	ХЗДХ-ийн сайдын А/25 дугаар тушаал
5	Нэг цэгийн үйлчилгээний төвийн аюулгүй байдлыг хангах журам	2017.02.14	ХЗДХ-ийн сайдын А/38 дугаар тушаал
6	Хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулах журам	2017.03.13	ХЗДХ, ХНХ-ийн сайдын хамтарсан А/56, А/31 дүгээр тушаал
7	Хохирогч хүүхдийг түр хамгаалалтаар хангах журам	2017.02.14	ХЗДХ-ийн сайдын А/39 дүгээр тушаал
8	Зан үйлд нөлөөлөх албадан сургалт ын журам	2017.04.04	ХЗДХ-ийн сайдын А/73 дугаар тушаал

Цагдаагийн байгууллагаас гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиг үүргээ хэрэгжүүлэхдээ дараахь стандартыг мөрдөн ажиллаж байна:

- 326. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх А/263
- 511. Гэрч, хохирогчийг хамгаалах А/265
- 317. Бэлэгсийн гэмт хэргийн насанд хүрээгүй хохирогчийн талаар авах арга хэмжээ А/263

- 313. Хүүхдийн эрхийг хангах А/263
- 227. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх А/262
- 209. Шуурхай удирдлагын албаны үйл ажиллагаа А/262
- 222. Байгууллага, иргэний орон байранд нэвтрэн орох А/262
- 401. Эргүүлийн үүрэг гүйцэтгэх А/264
- 201. Ноцтой гэмт хэргийн талаар мэдээлэх А/262

Түүнчлэн нутаг дэвсгэр хариуцсан буюу аймаг, дүүргийн цагдаагийн газрын Урьдчилсан сэргийлэх хэлтэс болон Хэв журмын тасгийн дарга, ахлах байцаагч болон Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан мэргэжилтэн, сэтгэл зүйч, хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагчийн ажлын байрны тодорхойлолтод гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчтой ажиллах тодорхой чиг үүргийг тусгасан байна.

Тухайлбал, Орон нутгийн цагдаагийн байгууллагын Урьдчилан сэргийлэх хэлтсийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлогыг хэрэгжүүлэх ажлыг арга зүй, зохион байгуулалтаар хангах, тус үйл ажиллагаанд олон нийтийг татан оролцуулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд энэ хүрээнд:

- Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төсөв, зардлын тооцоог хийж холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх;
- Хамтарсан багийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;
- Алба хаагчдыг чадавхижуулах ажлыг зохион байгуулах;
- Цагдаагийн алба хаагчаас хэрэгжүүлэх хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, хохирогчийг хамгаалах, энэ чиглэлд явуулж байгаа урьдчилан сэргийлэх ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах;
- Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэгтэй байна.²⁵

Хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагчийн ажлын байрны тодорхойлолтонд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үүргийг заасан бол сэтгэл

25 2017 онд батлагдсан Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын Урьдчилан сэргийлэх хэлтсийн гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтын хуулбар. ЦЕГ. 2017 он.

зүйчийн ажлын байрны тодорхойлолтод эрсдлийн зэрэг “өндөртэй” гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид сэтгэл зүйн зөвлөгөө туслалцаа үзүүлэхээс гадна тухайн гэмт хэргийг шалгаж байгаа алба хаагчдад мэргэжлийн дэмжлэг үзүүлэх, албадан сургалтанд хамруулах шийтгэл бүхий этгээдэд сэтгэл зүйн сургалт явуулах чиг үүрэг тусгагдсан байна.²⁶

Гэвч эдгээр албан тушаалд тавигдах шаардлагад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр тусгай сургалтад хамрагдсан байх, Урьдчилан сэргийлэх хэлтсийн чиглэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн энэ чиглэлээр мэргэшсэн байх гэсэн шалгуур тусгагдаагүй байна.

3.2. Гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох чиг үүргийн хэрэгжилт

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5-д зааснаар цагдаагийн байгууллага нь гомдол, мэдээллийг харьяалал харгалзахгүй хүлээн авч таслан зогсоох, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээг шуурхай авах үүрэгтэй.

Цагдаагийн байгууллага нь гэр бүлийн хүчирхийллийн талаарх гомдол, мэдээллийг цагдаагийн 102 дугаарын утсаар хүлээн авч дуудлагын шуурхай багт, эсхүл иргэн, хуулийн этгээд, албан тушаалтны гаргасан өргөдөл, гомдол хэлбэрээр хүлээн авч, гэмт хэрэг, зөрчлийг шалгах чиг үүрэг бүхий харьяалах нэгж, албанд шилжүүлдэг байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/262 дугаар тушаалаар батлагдсан Шуурхай удирдлагын албаны үйл ажиллагааг зохицуулах журамд зааснаар мэдээлэл хүлээн авагч нь мэдээллийг шуурхай хүлээн авахын зэрэгцээ яаралтай тусламж очих нөхцлийг хангах зорилгоор хаяг, байршлыг зөв тогтоох, шаардлагатай бол иргэнд аюулгүй байдлаа хэрхэн хангах талаар зөвлөгөө өгөх үүрэгтэй юм.

Мөн гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээллийг хүлээн авахдаа дараахь нэмэлт мэдээллийг тодруулж, хэргийн газарт байгаа ул мөрийг болон өөрийн аюулгүй байдлыг хангах зөвлөгөө, сэтгэл зүйн туслалцаа өгөхөөр заасан:

26 2017 онд батлагдсан Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын сэтгэл зүйчийн ажлын байрны тодорхойлолтын хуулбар. ЦЕГ. 2017 он.

- Хэргийн нөхцөл байдал, хохирогчийн аюулгүй байдалд одоо заналхийлж байгаа эсэх;
- Хохирогчид эмнэлгийн яаралтай тусламж шаардлагатай эсэх;
- Хохирогчид хамгаалалт шаардлагатай эсэх;
- Хүчирхийлэл үйлдэгч согтуурсан, мансуурсан эсэх;
- Зэвсэг, зэвсгийн чанартай эд зүйл хэрэглэсэн эсэх;
- Хүчирхийлэл үйлдэгч хохирогчтой ямар хамааралтай;
- Гэр бүлийн хүчирхийллийн талаар урьд өмнө цагдаагийн болон бусад байгууллагад хандаж байсан эсэх;
- Хүчирхийлэл үйлдэгч зугтаасан бол аль зүгт явсныг болон сэжигтнийг эрэн сурвалжлахад шаардлагатай бусад мэдээлэл.

Ийнхүү Шуурхай удирдлагын албаны үйл ажиллагааг зохицуулах журамд хохирогчийн аюулгүй байдалтай холбоотой нөхцөл байдлыг тодруулах, өөрийгөө хэрхэн хамгаалах талаар зөвлөгөө өгч, тайвшруулах арга хэмжээ авахаар заасан нь дэвшилттэй боловч дуудлага тасарсан, хаанаас, хэн залгаж байгаа нь тодорхойгүй дуудлагын дагуу авах арга хэмжээ, түүнчлэн хэл яриа, сонсголын бэрхшээлтэй иргэдийн дуудлагыг хэрхэн авах талаар нарийвчилсан зохицуулалт тусгагдаагүй байна.

Би төрөлхийн хэлгүй дүлий. Нөхөртөө зодуулаад цагдаа руу мессеж бичсэн чинь над руу цагдаагаас эргүүлээд залгахад манай нөхөр миний утсыг аваад цагдаа руу юу ч болоогүй, зүгээр гэж хэлсэн юм шиг байгаа юм. Цагдаа ирээгүй. Нөхөр намайг цагдаа дуудлаа гэж улам дарамтлаад би гадаа хоносон.

ХЭҮТ-ийн үйлчлүүлэгчийн тэмдэглэлээс

Хуулиар гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдээллийг хүлээн авмагц цагдаагийн алба хаагч нь түүнийг таслан зогсоох, хохирогчийг хамгаалах арга хэмжээг даруй авах үүргийг хүлээсэн. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар “даруй” гэдэг нь боломжит хамгийн богино хугацааг²⁷ илэрхийлж байна.

2018 оны 1 дүгээр сараас эхлэн цагдаагийн байгууллагын 102 утсанд ирсэн дуудлагын дүн бүртгэлд хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой дуудлагыг тусгайлан бүртгэж эхэлсэн бөгөөд 2018 оны эхний 10 сарын байдлаар гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй холбоотой 32878

²⁷ “даруй” гэж боломжит богино хугацааг. ЭХХШТХ-ийн 1.4 дүгээр зүйлийн 1.7 дахь заалт.

дуудлага хүлээн авснаас 4358 дуудлагад буюу 13.2%-д нь 20 минутаас дээш хугацаа алдаж очсон байна.

Өөрөөр хэлбэл, гэр бүлийн хүчирхийллийн дуудлагаар хэрэг, зөрчлийн газарт хүрэлцэн очих хамгийн богино боломжит хугацааг дуудлага хүлээн авснаас хойш 20 минут гэж цагдаагийн байгууллага тооцож байна.

Гэвч бүртгэлийн мэдээлэлд 170 тохиолдолд цагдаагийн алба хаагчийг очиход хүчирхийлэл үйлдэгч байхгүй байсан бол 75 тохиолдолд гарч зугтаасан гэжээ.²⁸



Зураг 9. Дуудлагад хугацаа хожигдсон шалтгаан

20 минутаас дээш хугацаа алдсан шалтгааныг тодруулахад **83.2% нь давхар дуудлагатай, 7.4% нь холын дуудлага** байсан тул хугацаа алдсан, 6.8% нь замын түгжрэл, ачаалалтай байдлаас, 2.5% нь автомашины эвдрэл, гэмтлээс гэжээ.

Цагдаагийн байгууллагын мэдээллээс хүүхдийн эсрэг болон гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой нийт дуудлагын 89%-д нь дуудлага хүлээн авснаас хойш 20 минутанд багтан хэргийн газарт цагдаагийн алба хаагч хүрэлцэн очжээ. Харин 7 дуудлага тутмын 1-д 20 минутаас дээш хугацаанд буюу хожимдож очсон байна.

Мониторингийн ажиглалтаар дуудлага, мэдээлэл ирсэн даруй эргүүл хамгийн түрүүнд очдог, дуудлагын утас тасарсан тохиолдолд мэдээлэл өгсөн иргэн рүү эргэж холбогддог, дуудлагыг үгүйсгэсэн тохиолдолд ч газар дээр нь очиж шалгах ажиллагаа хийдэг зэрэг дэвшил гарчээ.²⁹

28 Мэдээлэл, шуурхай удирдлагын газрын бүртгэл. 2018 он.

29 Ажиглагчийн тэмдэглэлд хийсэн дүн шинжилгээ. 2018 он. ХЭҮТ

Гэвч гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээлэл хүлээн авсан бол газар дээр нь яаралтай хүрэлцэн очиж нөхцөл байдлыг шалгах үүргийн хэрэгжилт хангалтгүй байна.

Үнэлгээний ажиглалтаар гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээлэл хүлээн авснаас хойш цагдаагийн алба хаагч хамгийн бага нь 3-5 минут, хамгийн ихдээ 1 цаг 50 минутын дотор хэрэг, зөрчлийн газарт хүрэлцэн очжээ.³⁰

Хугацаа алдаж байгаа шалтгааныг тодруулахад дуудлага давхардсан, ажиллах бүрэлдэхүүн байхгүй, хэргийн газарт 2-оос доошгүй цагдаагийн алба хаагч очих заалттай ч хөдөө орон нутгийн хувьд хүн хүч дутмаг, холын дуудлагад очих унаа хүрэлцдэггүй зэрэг шалтгааныг нэрлэсэн байна.³¹

Цагдаагийн алба хаагч дуудлага хүлээн аваад эргүүлийн цагдаад дамжуулсан боловч “хол байна” гэсэн тул машин хайж эхэлсэн. Мөн хамт явах цагдаа хайж 2 ч алба хаагч руу залгасан боловч боломжгүй гэсэн хариу сонссон. Тэгээд машин нилээд хүлээж байгаад дуудлага хүлээн авснаас хойш 1 цаг 50 минутын дараа очсон.

Үнэлгээний хүрээнд хийсэн ажиглалтын тэмдэглэлээс

Гэр бүлийн хүчирхийллийн талаарх дуудлага, мэдээлэл бүрт хариу үйлчлэл үзүүлж хэвшсэн бөгөөд дуудлагын дарааллыг тогтоохдоо аюултай нөхцөл байдлаас гадна гэр бүлийн хүчирхийллийн дуудлага гэдэгт анхаарал хандуулах болжээ.

Дуудлага хүлээн авсан дарааллыг баримталдаг боловч аюултай нөхцөл байдлыг харгалзан гэр бүлийн хүчирхийллийн дуудлагад түрүүлж очих заавартай. Заавал очиж шалгах ажиллагааг хийдэг.

Цагдаагийн алба хаагчтай хийсэн ярилцлагаас

Гэвч цагдаагийн алба хаагч гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн сэтгэл зүйн онцлог, эрсдэлтэй нөхцөл байдлыг үнэлэх болон хохирогчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэхээ мэдэхгүй байх нь түгээмэл байна.

30 Үнэлгээний мэдээлэл цуглуулагчийн ажиглалтын тэмдэглэлд хийсэн нэгтгэл. 2018 он.

31 Үнэлгээний хүрээнд хийгдсэн ярилцлагын дүнгийн нэгтгэл. 2018 он.

Хохирогч нилээд айсан байдалтай, тодорхой зүйл хэлж чадахгүй байсан ч дуудлагаар очсон цагдаагийн алба хаагч хэрхэн тайвшруулахаа мэдэхгүй байсан. Зөвхөн юу болсон талаар тодруулж асуугаад, дараа нь хүчирхийлэл үйлдэгчийг гэрээс нь авч явсан. Харин гарахдаа хохирогчид та маргааш цагдаагийн хэсэг дээр ирж уулзаарай гэж хэлсэн.

Хохирогчтой хийсэн ярилцлагаас

Цагдаагийн алба хаагч хуулиар өөрт олгогдсон эрх хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх талаарх ойлголт сул, хүлээсэн үүргээ хэрхэн хэрэгжүүлэх арга зүйн мэдлэг, ур чадвар дутмаг байгаа нь тэдэнд чиглэсэн сургалтын агуулга зөвхөн хуулиар хүлээсэн үүргийг танилцуулах хүрээнд хийгдэж байгаатай холбоотой байна.

Мөн гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээллийн эхний 3 удаагийн тохиолдлыг зөрчилд тооцон арга хэмжээ авдаг ч Зөрчлийн тухай хуульд заасан зөрчилд тооцох үйлдэл биш бол хариуцлага хүлээлгэх эрхгүй байдаг гэж ярилцлагад хамрагдсан цагдаагийн алба хаагчдын дийлэнх хувь нь хариулсан байна.³²

...Ихэнхдээ л архи ууж маргалдсан, айлгасан, хэл амаар доромжилсон гэх мэт ахуйн шинжтэй дуудлага байдаг. Энэ нөхцөлд авах арга хэмжээ байхгүй тул сануулаад л өнгөрдөг.

Цагдаагийн алба хаагчтай хийсэн ярилцлагаас

Зарим тохиолдолд цагдаагийн алба хаагч гэр бүлийн хүчирхийллийн дуудлагыг үл ойшоох, ноцтой гэж үзэхгүй байх, гомдлоо заавал бичгээр гаргахыг шаардах, давтан дуудлагад очихгүй байх зэргээр чирэгдэл учруулах тохиолдол байгааг дурьдсан.

Би цагдаад олон удаа дуудлага өгч байгаа. Нөхөр минь эрүүл согтуу хэзээ ч хамаагүй байнга зодож бие махбодид минь хүрдэг. Тэр болгонд би цагдаа дууддаг. Зарим дуудлагад нөхөр чинь эрүүл юм уу, согтуу юм уу гэж асуудаг. Одоо нөгөө хүүхэн байна гэж боддог юм байлгүй ирэх нь удаашраад байгаа.

Хохирогчтой хийсэн ярилцлагаас

³² Үнэлгээний хүрээнд авсан асуулгын дүнгийн нэгтгэлээс.

Нэвтрэн орох ажиллагаа

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсэг, Цагдаагийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлд цагдаагийн алба хаагч дуудлага, мэдээллийн дагуу хэрэг, зөрчлийн газарт шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг хуульчилсан.

Тус арга хэмжээг хэрэгжүүлэх журам, анхаарах асуудлыг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/263 дугаар тушаалаар батлагдсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны журмаар нарийвчлан зохицуулж байна.


Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд зааснаар цагдаагийн алба хаагч нь хүчирхийллийг таслан зогсоох зорилгоор бусдын орон байранд нэвтрэн орж, хохирогчийн аюулгүй байдлыг шалгах үүрэгтэй.

Нэвтрэн орох ажиллагааг Цагдаагийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан журмаар хэрэгжүүлэх бөгөөд гэр бүлийн хүчирхийлэл нь хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах эрсдэлтэй байдаг тул энэ тохиолдолд заавал эзэмшигчээс нь зөвшөөрөл авсан байхыг шаардахгүй.

Нөхөр гэрийн хаалгыг дотроос нь түгжээд онгойлгож өгөхгүй байсан. Цаана нь хүүхэд уйлаад байхад дуудлагаар ирсэн цагдаа манай хаалгыг нүдэж байгаад нөхөр чинь эрүүл юм байна, бид хүний өмчийг эвдэх боломжгүй гээд орхиод явсан.

ХЭҮТ-ийн үйлчлүүлэгчийн тэмдэглэлээс

2018 оны байдлаар 102 утсанд ирсэн дуудлагаар ажилласан мэдээлэлд хаягаар очиход 4 тохиолдолд хаалгаа тайлж өгөөгүй бөгөөд эдгээр нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна.



Зураг 10. Нэвтрэн орох ажиллагааны хэрэгжилт

Цагдаагийн алба хаагч нь хүчирхийллийг таслан зогсоох зорилгоор бусдын орон байранд нэвтрэн орж, хохирогчийн аюулгүй байдлыг шалгах үүрэгтэй болох талаар харилцан адилгүй ойлголттой байдаг нь үнэлгээний дүнгээс харагдсан.

Мэдээллийн сан ашиглалт

Гэр бүлийн хүчирхийллийн дуудлагаар ажиллаж буй цагдаагийн алба хаагч нь хэргийн газарт шуурхай очих, хохирогч болон гэр бүлийн бусад гишүүдийн аюулгүй байдлыг шалгах, аюулын зэргийн үнэлгээ хийхэд тухайн гэр бүлийн гишүүдийн болон хүчирхийлэл үйлдэгчийн талаарх мэдээллийг урьдчилан авсан байх нь чухал байдаг.

Энэхүү мэдээлэл нь дуудлага, мэдээллээр ажиллах дарааллыг тогтоохоос эхлээд тухайн орон байранд нэвтрэн орох, аюулгүй байдлыг шалгах ажиллагааг хэрхэн явуулах арга тактикийг сонгох боломжийг олгоно.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-д “хүчирхийлэл үйлдэгч, хохирогчийн талаарх бүртгэл хөтлөх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, ашиглах” үүргийг цагдаагийн байгууллагад хүлээлгэсэн.

Үүний дагуу Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/249 тушаалаар батлагдсан Судалгаа, хяналтын тоо бүртгэл хөтлөх журамд хэсгийн байцаагч, хэсгийн төлөөлөгч, хороо хариуцсан эрүүгийн мөрдөгч нь “гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн бүртгэл” хөтлөх үүрэгтэй байна.

Цагдаагийн ерөнхий газраас ирүүлсэн мэдээлэлд “Цагдаагийн

байгууллагын бүртгэл, судалгаа 2009 оноос өмнө цаасан бүртгэлд тулгуурлаж байсан бол 2010 оноос цахимжуулах, олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор үе шаттайгаар бүртгэлийн системийг сайжруулсаар өнөөг хүрсэн. Ялангуяа НҮБ-ын Хүн амын сантай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу “Гэр бүлийн хүчирхийллийн мэдээллийн сан” бий болгох боломж нээгдсэн.

Гэр бүлийн хүчирхийллийн мэдээллийн санг түшиглэн эхний ээлжинд нийслэлийн хэмжээнд эргүүлийн цагдаагийн алба хаагч нарт дуудлага, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, үйл ажиллагаандаа ашиглах “Таблет” олгогдсон ба энэхүү төхөөрөмжөөр мэдээллийн сангаас боломжит бүх мэдээллийг шууд авч хүчирхийллийн түүхийг шалгах, хохирогчид ашигтай буюу түүний эрүүл мэнд, амь насыг хамгаалах шийдвэр гаргахад ашиглах боломж нээгдэж байна. Гэр бүлийн хүчирхийллийн мэдээллийн санг ашиглалтад оруулж, дээрх сангийн нээлтийн арга хэмжээг 2018 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр зохион байгуулсан.”³³

Нийслэлийн төвийн 6 дүүргийн эргүүлийн 62 чиглэлд хөдөлгөөнт төхөөрөмж байршуулж, дуудлага мэдээллийг хүлээн авч шийдвэрлэлтийг газар дээрээс нь оруулдаг болсноор тухайн дуудлага өгсөн утаснаас өмнө нь дуудлага өгч байсан мэдээллийн түүх, авсан арга хэмжээний мэдээллийг цагдаагийн алба хаагч шууд харах боломжтой болсон³⁴.

Ийнхүү мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах ажлыг шат дараатай гүйцэтгэж байгаа ч дээрх мэдээллийн сан нь зөвхөн дуудлага, мэдээлэлд үндэслэсэн бөгөөд хүчирхийлэл үйлдэгчийн овог нэр, гэмт хэрэгт холбогдсон эсэх, эсхүл урьд нь хүчирхийлэл үйлдэж байсан эсэх зэрэг мэдээллийг хамруулсан нь цагдаагийн алба хаагч хэргийн газарт шуурхай очих, хохирогч болон гэр бүлийн бусад гишүүдийн аюулгүй байдлыг шалгах, аюулын зэргийн үнэлгээ хийхэд учир дутагдалтай байна.

Үнэлгээний хүрээнд цугларсан мэдээлэлд 2018 оны 10 дугаар сарын байдлаар сонгосон хороодод хийсэн ажиглалтаар “Хэсгийн байцаагч, цагдаа нь гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдээллийн санд мэдээлэл оруулдаг боловч эргээд тэрхүү мэдээллийг ашиглах боломжгүй”³⁵ байна.

33 Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтсийн мэдээлэл. 2018 оны 11-р сар.

34 ЦЕГ-ын дэд дарга, цагдаагийн хурандаа З.Дашдаваагийн илтгэл, 2018-11-30

35 Үнэлгээний мэдээлэл цуглуулагчийн ажиглалтын тэмдэглэлд хийсэн нэгтгэл. 2018 он.

Сүлжээ муу тул мэдээллийн сангаас мэдээлэл авахад хүндрэлтэй байдаг. Мөн мэдээллийн сангаас мэдээлэл харах, авах эрхгүй тул авч чаддаггүй учир дүүргийн нэгдсэн сангаас л мэдээлэл авдаг.

Цагдаагийн алба хаагчтай хийсэн ярилцлагаас

Бодит байдалд тус мэдээллийг цагдаагийн алба хаагчид өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглах бус, зөвхөн тайлан мэдээ гаргах байдлаар хэрэглэж байна.

Дуудлага, мэдээллээр ажиллахад хүчирхийлэл үйлдэгч хэн бэ? гэхээс илүүтэй хохирогчийн нөхцөл байдал (хэн хэнтэйгээ амьдардаг, эрүүл мэнд, сэтгэл зүйн байдал), шаардлагатай бол нэвтрэн орох боломж (байршил, орон байранд нь гаднаас хэрхэн нэвтрэх боломжтой), хүчирхийлэл үйлдэгчийн зан байдал, галт зэвсэг эзэмшдэг эсэх зэрэг мэдээлэл нэн чухал юм.

Гэтэл бодит байдалд цагдаагийн алба хаагч нь:

- Гэрийн хаяг;
- Хэнийх гэдэг айл;
- Тухайн этгээд архи, согтууруулах ундаа хэрэглэдэг эсэх, урьд нь гэмт хэрэг, зөрчилд холбогдож байсан эсэхээс өөр мэдээлэлгүйгээр хэргийн газарт очиж байна.

Энэ нь хохирогчийн аюулгүй байдлыг бодитой үнэлэх боломжийг бууруулах, улмаар цагдаагийн алба хаагч өөрийн аюулгүй байдлыг ч алдахад хүргэдэг.

Цагдаагийн байгууллагын 2018 оны яаралтай дуудлагын бүртгэлд 27 холбогдогчийг хэрцгий, догшин авиртай, 14 холбогдогчийг хутга, зэвсгийн чанартай зүйл хэрэглэх магадлалтай, 9 холбогдогчийг хохирогчийн амь насанд аюул учруулах магадалтай, 106 холбогдогчийг удаа дараа хүчирхийлэл үйлдэж байсан гэж мэдээлжээ.³⁶

Мэдээллийн сан зөвхөн ажлын цагаар л ажилладаг. Ажлын цаг дууссан тохиолдолд мэдээллийн санг ашиглах боломж байдаггүй.

Орон нутгийн цагдаагийн алба хаагчтай хийсэн ярилцлагаас

36 Мэдээлэл, шуурхай удирдлагын газрын бүртгэл. 2018 он.

Иймд нэгэнт бий болсон энэхүү мэдээллийн санг хохирогчийн болон өөрийн аюулгүй байдлыг бүрэн үнэлэх боломжийг бүрдүүлж шаардлагатай мэдээллээр өргөжүүлж, цагдаагийн алба хаагч өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглах боломжийг олгож, хэвшүүлэх шаардлагатай юм.

Мөн Цагдаагийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасан цагдаагийн байгууллагын тусгай мэдээллийн сан, сүлжээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой төрөлжсөн санг заагаагүй байх тул хуулийн зохицуулалт хоорондын уялдааг хангах шаардлагатай нь харагдсан.

Аюулын зэргийн үнэлгээ

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд зааснаар цагдаагийн алба хаагч нь дуудлага, мэдээллийн дагуу хэргийн газар, эсхүл хохирогчийн байгаа газарт очиж аюулгүй байдлыг шалгах, аюулын зэргийн үнэлгээг хийх бөгөөд энэхүү үнэлгээ нь хохирогч, түүний гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах үндэслэл болно.



Зураг 11. Аюулын зэргийн үнэлгээний хэрэгжилт

Аюулын зэргийн үнэлгээгээр хохирогч, хүчирхийлэл үйлдэгчтэй нэг орчинд байх нь аюултай эсэхийг тогтоодог тул үнэлгээг хүчирхийлийн тохиолдол бүрт богино хугацаанд гүйцэтгэж, улмаар “хохирогчийн аюулгүй байдлыг хангах” шийдвэрийг яаралтай гаргах үндэслэл болгон ашиглах ёстой.

37 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 31 дүгээр зүйл.

38 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4.1 дэх заалт.

Гэтэл практикт аюулын зэргийн үнэлгээг хуульд заасан үндсэн зорилгын дагуу биш нотолгооны хэрэгсэл буюу хүчирхийлэл үйлдэгдсэн эсэх, хүчирхийлэл үйлдэгчид хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээг тогтоох нотлох баримт болгон ашиглаж байна.

Тухайлбал Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн А/37 дугаар тушаалаар баталсан Аюулын зэргийн үнэлгээ хийх журам нь хуулийн зорилтоос гажсан бөгөөд зөвхөн нотолгоо бүрдүүлэх чиглэлд анхаарал хандуулсантай холбоотой байна.

Дээрх журамд аюулын зэргийн үнэлгээг насанд хүрэгч болон хүүхдийн гэсэн 2 төрлөөр хийх бөгөөд тус бүр 20 асуулт бүхий (А4 цаасны хэмжээтэй 4 нүүр) мэдээллийг цагдаагийн алба хаагч гараар тэмдэглэхээр заасан бөгөөд дуудлагаар ажиллаж буй албан тушаалтан өөрийн болон хохирогч, хүчирхийлэл үйлдэгчийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тусгаж, эцэст нь хохирогчийн гарын үсгээр баталгаажуулахаар байна.

Аюулын зэргийн үнэлгээг хийх журмын 2.1-т “Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээллийг удаа дараа ирүүлсэн хохирогчид аюулын зэргийн үнэлгээг тохиолдол бүрт хийнэ”, мөн журмын 2.7-д “ ... 2 ба түүнээс дээш тооны хохирогч байгаа тохиолдолд аюулын зэргийн үнэлгээг тус бүрт нь хийнэ, 2.10-т” Цагдаагийн алба хаагч гарын үсэг зурж баталгаажуулсан аюулын зэргийн үнэлгээг хохирогчид танилцуулж гарын үсэг зуруулна” гэж заажээ.

Аюулын зэргийн үнэлгээг удаа дараа дуудлага, мэдээлэл ирүүлсэн (3 буюу түүнээс дээш удаа) хохирогчид хийхээр байгаа нь үүнээс бусад тохиолдолд эрсдлийг хэрхэн үнэлэх, цагдаагийн алба хаагч юунд үндэслэн хохирогчийг яаралтай хамгаалалтаар хангах шийдвэр гаргах нь тодорхойгүй байна.

2018 оны эхний 10 сарын байдлаар цагдаагийн байгууллагын 102 дугаарын утсанд хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой ирсэн дуудлагын 1216 тохиолдлыг нь гэр бүлийн хүчирхийлэлд тооцож, 1179 аюулын зэрэг тогтоох үнэлгээ хийсэн бол 155 тохиолдолд үнэлгээ хийгээгүй гэжээ.³⁹

Ажиглалтаар аюулгүй байдлын үнэлгээний маягтыг бөглөж, хохирогчоор гарын үсэг зуруулан баталгаажуулахын тулд цагдаагийн алба хаагч 20-40 минут зарцуулж байна.

³⁹ Мэдээлэл, шуурхай удирдлагын газрын бүртгэл. 2018 он.

Аюулын зэргийн үнэлгээг хийх журам-д" үнэлгээг 2-оос дээш хохирогч байгаа бол хохирогч тус бүрт хийнэ." гэсэн тул (гэр бүлийн хүчирхийллийн хэрэг нь дунджаар 3-5 хохирогчтой байдаг) дуудлагаар очсон алба хаагч үнэлгээнд 2-3 цаг зарцуулах шаардлагатай болж байна.

Мөн тус журмын 2.13-т "Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээллийн дагуу ажилласан цагдаагийн алба хаагч аюулын зэргийн үнэлгээг холбогдох материалын хамт шийдвэрлүүлэхээр эрх бүхий албан тушаалтанд өгнө", 2.14-т "Цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан аюулын зэргийн үнэлгээ холбогдох материалын хамт хүлээн аваад Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, бусад хууль тогтоомжид заасан арга хэмжээг нэн даруй авна." гэж заасан нь дуудлагаар ажиллаж байгаа цагдаагийн алба хаагч үнэлгээг үндэслэн шийдвэр гаргах бус харин гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг шалган тогтоох ажиллагааг хэрэгжүүлэх албан тушаалтанд нотлох баримт болгон шилжүүлэхээр болж байна.

Аюулын зэргийн үнэлгээг 9 хохирогчид хийсэн. Үнэлгээг хэргийн материалд хавсаргаж, прокурорт хүргүүлсэн тул үзүүлэх боломжгүй байна.

Цагдаагийн алба хаагчтай хийсэн ярилцлагаас

Үүнээс шалтгаалан цагдаагийн алба хаагч нь аюулын зэргийн үнэлгээг цаг тухайд нь бус нотлох баримт болгох зорилгоор сүүлд нь нөхөж хийхэд хүргэдэг байна.

Аюулын зэргийн үнэлгээний олон хуудсыг бөглөх нь цагдаагийн алба хаагчийн шуурхай ажиллагаанд нөлөөлж байна. Цагдаагийн алба хаагч нь дуудлагаар ажиллах үеийн нөхцөл байдал, аюултай болон эрсдэлтэй нөхцөлд авч хэрэгжүүлсэн арга хэмжээг дуудлагаар ажилласан тэмдэглэлд тусгах мөн аюулын зэргийн үнэлгээг цаасан хэлбэрээр тусгайлан хийж байгаа нь ажиллагааны хувьд давхардал үүсгэж байна.

Аюулын зэргийн үнэлгээг хийх шалгуур асуулт нь хохирогчийн аюулгүй байдалтай холбоотой нөхцөл байдлыг илэрхийлэхээс илүү хохирлыг нотлоход чиглэгдсэн байна.

Мөн ажиглалтаар тогтоох боломжтой хохирогч, хүчирхийлэл үйлдэгчийн сэтгэл зүйн байдал, хүүхэд, өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эрсдэл учруулж болзошгүй нөхцөл байдлыг тогтооход чиглэсэн асуулт байхгүй нь ажиглагдлаа.

Ойлгоход хүндрэлтэй, оновчтой биш асуулт их байдаг. Жишээ нь, айдас, бухимдалтай байгаа хохирогчоос та санхүүгийн дарамтад байдаг уу? гэх зэргээр хөндлөнгийн мэт асуулт асуух нь тэднийг улам бухимдуулахад хүргэдэг.

Уг нь хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчтэй нэг орчинд үлдээх нь эрсдэлтэй эсэхийг тогтоохын тулд чухал шаардлагатай цөөн үзүүлэлтийг харгалзах, ажиглалт болон ярилцлагын явцад үнэлгээг хийх боломжийг бүрдүүлэх нь илүү ач холбогдолтой.

Цагдаагийн алба хаагчтай хийсэн ярилцлагаас

Иймд аюулын зэргийн үнэлгээ хийх асуултыг оновчтой, хэрэглэхэд хялбар болгох, түүнчлэн үнэлгээг хүчирхийллийн тохиолдол бүрт хийж, хохирогчийн аюулгүй байдлыг яаралтай хамгаалахтай холбоотой шийдвэр гаргах үндэслэл болгоход ашиглахуйц болгох шаардлагатай байна.

Хохирогчийг мэдээллээр хангах

Гэр бүлийн хүчирхийллийн дуудлагаар ажиллаж байгаа цагдаагийн алба хаагч нь хохирогчид хуульд заасан эрх, үүргийг нь тайлбарлаж, түүнд үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээллийг бичгээр өгөх үүрэгтэй.

Гэр бүлийн хүчирхийллийн дуудлагаар ажилласан цагдаагийн ажилтан хохирогчдын 62 хувийг уурласан, 34 хувь нь айсан байдалтай байсан хэмээн тодорхойлсон байна.⁴⁰ Эндээс сэтгэл зүйн хувьд тайван бус, айдастай байгаа хохирогч цагдаагийн алба хаагчаас өгч буй мэдээллийг бүрэн хүлээн авах боломжгүй байдаг нь ойлгомжтой юм.

Ихэнх тохиолдолд цагдаагийн алба хаагч хохирогчийг мэдээллээр хангах үүргээ хэрэгжүүлдэггүй бөгөөд хаана хандаж болохыг хэлж өгсөн цөөхөн тохиолдол ажиглагдсан байна.

Хохирогчид үйлчилгээний талаар ямар нэгэн мэдээлэл өгөөгүй, энэ тухай нийгмийн ажилтанд ч мэдэгдээгүй. Урьд өмнөх нөхцөл байдлын талаар асуугаагүй, зөвхөн сүүлчийн тохиолдлын талаар л тодруулсан.


Ажиглалтын тэмдэглэлээс

40 Мэдээлэл, шуурхай удирдлагын газрын бүртгэл. 2018 он.

Анхан шатны нэгж дээр ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчид хохирогчдод зориулсан мэдээллийн хуудсаар хангагдаагүй бөгөөд ажиглалтаар мэдээллийн хуудас ашигласан нэг ч тохиолдол байхгүй байна.⁴¹

Цагдаагийн ерөнхий газраас өгсөн мэдээллээр хохирогчид зориулсан мэдээллийн хуудсыг хэвлүүлэн түгээх ажлыг зохион байгуулж байгаа ч энэ нь гадны төсөл, хөтөлбөрийн хүрээнд цөөн тоогоор хэвлэгддэг (тогтвортой биш) байна.

Мөн хохирогчид зориулсан мэдээлэл нь хэт хуулийн үгээр бичигдсэн тул энгийн иргэн ойлгоход хүндрэлтэй төдийгүй хаана, хэнд хандаж, ямар үйлчилгээ, тусламжийг авах талаарх мэдээлэл нь дутмаг байна.



Зураг 12. Хохирогчид зориулсан мэдээллийн хуудас

Жишээ нь: Цагдаагийн ерөнхий газраас хэвлүүлсэн “Гэр бүлийн хүчирхийллийн мэдээллийн хуудас”-нд гэр бүлийн хүчирхийлэл, түүний төрөл, хохирогчийн эрх зэргийг заасан бөгөөд үйлчилгээний талаарх мэдээлэл хязгаарлагдмал, ойлгомжгүй байдлаар тусгагдсан байна. Тухайлбал:

“Та төрийн байгууллага, албан тушаалтнаас дараах үйлчилгээг үнэ төлбөргүй авах эрхтэй:

1. Аюулгүй байдлын хамгаалалт
2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ
3. Нийгмийн халамжийн үйлчилгээ
4. Хүүхэд хамгааллын үйлчилгээ
5. Эрх зүйн тусалцаа
6. Сэтгэл зүйн үйлчилгээ

41 Үнэлгээний хүрээнд хийгдсэн ажиглалтын дүнгийн нэгтгэл. 2018 он.

7. Холбон зуучлах" гээд үйлчилгээ үзүүлэх байгууллага, албан тушаалтанд зөвхөн

Нийслэлийн цагдаагийн газрын болон Хан-Уул дүүргийн түр хамгаалах байр, Хүүхдийн тусламжийн төв, Хүчирхийллийн эсрэг Үндэсний төв, Шүүх эмнэлэг, Гэмтэл согог судлалын үндэсний төвийн болон Сүхбаатар дүүргийн нэг цэгийн үйлчилгээний төвийн утасны дугаарыг бичсэн байна.

Энэхүү мэдээллийн хуудаснаас хохирогч яг ямар үйлчилгээ, дэмжлэг авах боломжтой талаар ойлголт авч чадахгүйгээс гадна энэ үйлчилгээг авахын тулд өөрт хамгийн ойр байх хороо, сум, багийн нийгмийн ажилтан, эмч, цагдаагийн ажилтан, Засаг даргад хандах бус заавал төвлөрсөн үйлчилгээний нэгжид хандах ёстой гэж ойлгогдохоор байна.

Зарим орон нутгийн цагдаагийн байгууллага нь хохирогчдод зориулсан тусламж, мэдээллийн хуудас хийж түгээж байгаа нь сайшаалтай ч агуулгын хувьд мөн дээрх алдааг давтсан ойлгомжгүй, шаардлагагүй мэдээллийг тусгасан А4 цаасны хэмжээтэй хийсэн тул олон тоогоор хэвлэхэд бэрхшээлтэй, цагдаагийн алба хаагч бэлэн авч явахад ч хүндрэлтэй байдаг байна.

Иймд хохирогчид бичгээр өгөх үйлчилгээний талаарх мэдээллийг ойлгомжтой, тодорхой (ямар үйлчилгээг, хаанаас, хэрхэн авч болох) илэрхийлсэн байдлаар дахин боловсруулах, хүртээмжтэй хэлбэрээр хэвлэн олшруулж байнга бэлэн байлгахад анхаарч төсөв санхүүжилтийг шийдвэрлэх шаардлагатай байна.

Хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 25 дугаар зүйлд зааснаар цагдаагийн алба хаагч нь дуудлага, мэдээллээр ажиллахдаа

- Хохирогч, түүний гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдлыг шалгах, аюулын зэргийн үнэлгээнд үндэслэн хохирогчийг түр хамгаалалтаар хангах арга хэмжээ авах;
- Аюулын зэрэг өндөртэй, эсхүл хүүхэд хүчирхийлэлд өртсөн бол нийгмийн ажилтанд мэдэгдэх;
- Шаардлагатай бол гэрч, хохирогчийг аюулгүй байдлыг тусгай хамгаалалтад хамруулах;
- Гэмт хэрэг, зөрчлийг шалгах ажиллагаатай холбоотой мэдээллээр хохирогчийг хангах зэрэг арга хэмжээг авах үүрэгтэй.


Цагдаагийн байгууллага 2018 оны эхний 10 сарын байдлаар 264 хохирогчийг нэг цэгийн үйлчилгээний төвд, 20 хохирогчийг түр хамгаалах байранд, 5 хохирогчийг эмнэлэгт, 16 хохирогчийг асрамж, халамжийн байгууллагад хүргэж, 864 хохирогчийг төрөл, садны болон хамгаалах боломжтой бусад хүний хамгаалалтанд үлдээж, 170 тохиолдолд хүчирхийлэл үйлдэгчийг албадан эрүүлжүүлэх арга хэмжээг авсан байна.⁴²



Зураг 13. Авсан арга хэмжээ, хохирогчийн тоогоор

ЦЕГ, 2018 оны 10 сарын байдлаар дуудлага, мэдээллийн дагуу ажилласан цагдаагийн ажилтан 1179 тохиолдолд аюулын зэргийн үнэлгээг хийснээс 409 тохиолдолд буюу 34.7% эрсдэл өндөр, 111 тохиолдол буюу 9.4% эрсдэл дунд зэрэг гэж тогтоогдсон байна.⁴³

Ажиглалтын явцад цагдаагийн алба хаагч нар аюулын зэргийн үнэлгээ хийхгүй байгаа шалтгаанаа “дуудлагаар очоод шууд хийх орчин нөхцөл байхгүй, цагдаагийн албан хаагчийн ажлын ачаалал их, дуудлага хүлээн авах бие бүрэлдэхүүний хүрэлцээ муу” байгаатай холбон тайлбарласан байна.



Зураг 14. Аюулын зэргийн үнэлгээний дүн, эрсдлийн зэргээр

43 Мэдээлэл, шуурхай удирдлагын газрын бүртгэлийн мэдээлэл. 2018 он.

Аюулын зэргийн үнэлгээ хийх журамд эрсдлийн зэрэг “өндөр” гарсан бол хохирогчийг яаралтай хамгаалалтаар хангах буюу хүчирхийлэл үйлдэгчээс тусгаарлах, харин эрсдэл “дунд” зэрэгтэй бол хохирогчийн санал болон бусад нөхцлийг харгалзан дээрх хамгаалалтанд хамруулахаар заасан.⁴⁴

Гэвч гэр бүлийн хүчирхийллийн дуудлага мэдээлэл болон хохирогчийг аюулгүй газар байрлуулсан талаарх тоон мэдээллийг харьцуулж үзвэл 10 дуудлага, мэдээлэл тутмын нэгд нь хохирогчийг түр хамгаалалтаар хангасан бөгөөд 2 хохирогч тутмын 1-ийг нь төрөл садан буюу ойр дотны хүнийх нь хамгаалалтад хүлээлгэн өгсөн байна.

Хэдийгээр аюулын зэргийн үнэлгээг үндэслэн түр хамгаалалтын арга хэмжээг авахаар хуульд заасан боловч уг арга хэмжээг хэт хавтгайруулан хэрэглэж, хохирогч болон хохирогчийг хамгаалалтад авсан хүнийг эрсдэлтэй нөхцөлд оруулсан тохиолдол гарч байна.

Цагдаа ирээд намайг хүүхдүүдийн маань хамт эгчийнд маань оруулж өгсөн.Эгчийнх манай хашаанд хамт байдаг.Эгч маань удаа дараа манай нөхрөөс намайг өмөөрсний төлөөзодуулж байсан.

Хохирогчтой хийсэн ярилцлага

Тухайлбал, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/263 дугаар тушаалаар батлагдсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны журмын 326.5.2-ын б/-д “гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч этгээдийг хохирогчтой нэг орчинд үлдээхгүй, хүчирхийллийн ямар ч тохиолдолд хохирогчоос тусгаарлах, цагдаагийн байгууллагад хүргүүлэх арга хэмжээ авах” гэж заасан байна.

Энэхүү арга хэмжээ нь нөхцөл байдлыг тодруулах, эрсдлийн үнэлгээ хийх ажиллагааны явцад хохирогчийг аюулгүй, тайван байдлыг хангах, үнэн бодит мэдээлэл авахад чиглэсэн газар дээр нь шуурхай хэрэгжүүлэх богино хугацааны тусгаарлалт юм.

Гэтэл үүнийг аюулгүй байдлын түр хамгаалалт буюу хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээнд хүргэх, хамаатан садан, ойр дотны хүний хамгаалалтад өгөх арга хэмжээтэй адилтган үзэж, хохирогч, эсхүл хүчирхийлэл үйлдэгчийг тусгаарлан байрлуулах, хэн нэг нь заавал гэрээсээ явах шаардлага болж хувирсан байна.

⁴⁴ Аюулын зэргийг үнэлэх аргачлал. 2017 он.

Хохирогчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээний хүрээнд өөрсдийн хүчээр авч болох арга хэмжээг тогтоох, яаралтай нөхцөлд цагдаагийн болон бусад хамгаалалт, тусламжтай хэрхэн холбогдох зэргийг хамтран төлөвлөх (Аюулгүй байдлын төлөвлөгөө)⁴⁵, хүчирхийлэл үйлдэгчид тодорхой нөхцөл бүхий шаардлага тавих боломжтой боловч практикт энэ аргыг хэрэгжүүлж байгаа тохиолдол бараг байхгүй байна.

Ийнхүү хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээг нөхцөл байдал, ач холбогдолыг харгалзахгүйгээр стандарт үйл ажиллагаа болгон нийтлэгээр хавтгайруулан хэрэгжүүлэх, төлөвлөлт гаргаж өөрсдийнх нь оролцоог хангахгүй байх, бусад хэлбэрээс илүү ойр дотны хүний хамгаалалтад өгөх журмаар бусдад үүрэг хүлээлгэх зэргээр ёс төдий хэрэгжүүлэх нь үр дүнгүй бөгөөд зарим тохиолдолд хохирогчид эрсдэл учруулж байна.

Манай хэсгийн байцаагч таны аюулгүй байдлыг хамгаалж байна гээд өвлийн хүйтэнд (2017-11-27) бага насны 2 хүүхэдтэй нүүлгэсэн. Нүүлгэх ажлыг нөхөрт даалгасан.

Хохирогчтой хийсэн ганцаарчилсан ярилцлагаас

Хууль хэрэгжиж эхлэхээс өмнө буюу 2015 оны байдлаар Улсын хэмжээнд түр хамгаалах байр 6, нэг цэгийн үйлчилгээний төв 4 ажиллаж байсан бол 2018 оны 10 дугаар сарын байдлаар түр хамгаалах байр 11, нэг цэгийн үйлчилгээний төв 12 болж хохирогчид аюулгүй байдлын хамгаалалт үзүүлэх нэгж даруй 2-3 дахин нэмэгдсэн нь дэвшилттэй боловч хангалтгүй хэвээр байна.⁴⁶

Үүнээс орон нутагт хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний хүртээмж муугаас хэрэгжүүлэхэд бэрхшээл тулгардаг төдийгүй хүчирхийлэл үйлдэгчийг түр саатуулах, баривчлах үндэслэлийг хуульд тодорхой тусгаагүйгээс дийлэнх тохиолдолд хохирогчийг ойр дотны хүний хамгаалалтад өгөх, эсхүл хохирогч гэрээсээ явахад хүрч байгааг анхаарах шаардлагатай байна.

45 Аюулгүй байдлын төлөвлөгөө гэдэг нь “хүчирхийллийн эрсдлээс урьдчилан сэргийлэх, эрсдэл учирсан нөхцөлд өөрийгөө болон бусдыгаа хамгаалахад чиглэсэн ажиллагааг хохирогч өөрийн болон гэр бүлийн бусад гишүүдийн хамт хэрэгжүүлэх төлөвлөгөө” юм.

46 НХХЯ-наас ирүүлсэн авсан мэдээлэл. 2018 он

Нөхөр чинь эрүүл байна, эрүүл хүнийг яаж ч болохгүй байна. Харин та хүүхдүүдтэйгээ нэг цэгийн үйлчилгээний төвд хоночих гээд хүргэж өгсөн.

ХЭҮТ-ийн үйлчлүүлэгчийн бүртгэлээс

Хохирогч хүүхдийг түр хамгаалалтаар хангах

Гэр бүлийн хүчирхийлэлд хүүхэд өртсөн тохиолдолд хохирогч хүүхдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор түр хамгаалалтаар хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр заасан.

Цагдаагийн байгууллагын мэдээллээр 265 хүүхдийг хамгаалах боломжтой хүн, төрөл саданд, 7 хүүхдийг нэг цэгийн үйлчилгээний төвд, 9 хүүхдийг түр хамгаалах байранд, 6 хүүхдийг асрамж, халамжийн байгууллагад хүлээлгэн өгсөн бол нэг хүүхдийг эмнэлэгт хүргэсэн байна. Мөн 30 тохиолдолд хүүхдийн асуудал хариуцсан байгууллага, албан тушаалтанд мэдэгдсэн гэжээ.⁴⁷



Зураг 15. Түр хамгаалалтаар хангагдсан хүүхдийн тоо, хамгаалалтад авагдсан газраар, 2018 он

Дээрх хамгаалалтын арга хэмжээг хүүхэд дангаараа хүчирхийлэлд өртсөн тохиолдолд голчлон хэрэгжүүлж байгаа бөгөөд бусад нөхцөлд насанд хүрэгчдэд учирсан эрсдлийг үнэлэх, тэдгээрт холбогдуулан арга хэмжээ төлөвлөх зэргээр хүүхдэд төдийлөн анхаарахгүй байх хандлага ажиглагдаж байна.

47 Мэдээлэл, шуурхай удирдлагын газрын бүртгэлийн мэдээлэл. 2018 он.

Хамтран амьдрагч маань намайг зодоод, 2 настай хүүхдийг минь аваад явчихлаа, туслаач гэж нэг эмэгтэй хандсан юм. Хүүхдийг авч түр хамгаалалтаар хангаж өгөөч гэж цагдаад хандсан боловч “Ээж нь согтуу байна, эрүүл болохоос нааш хүүхдийг эхэд нь өгөх боломжгүй, хамгаалах байранд ч асран хамгаалагчгүй хүүхэд авахгүй тул хамтран амьдрагчийнх нь түр хамгаалалтад байлгахаас өөр аргагүй” гэсэн хариу өгсөн.

ХЭҮТ-ийн зөвлөгчийн тэмдэглэлээс

Хүчирхийлэл үйлдэгчид авах арга хэмжээ:

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 25 дугаар зүйлд зааснаар цагдаагийн ажилтан нь дуудлагаар ажиллах явцдаа хүчирхийлэл үйлдэгчид холбогдуулан дараахь арга хэмжээг авах эрхтэй:

- хүчирхийлэл үйлдэх, согтууруулах ундаа хэрэглэхийг зогсоохыг шаардах;
- шаардлагатай бол баривчлах;
- галт зэвсэг, зэвсэг, зэвсгийн чанартай зүйлийг хураан авах;
- шаардлагыг биелүүлэхээс татгалзсан, эсэргүүцсэн бол албадлага хэрэглэх;
- хувцас, эм, эмнэлгийн хэрэгсэл, баримт бичиг, хүүхдийн сургалтын хэрэгсэл, шаардлагатай хэрэглээний эд зүйлээ авахад нь хохирогчид туслалцаа үзүүлэх, хүчирхийлэл үйлдэгчээс шаардан гаргуулах.

2018 оны эхний 10 сарын байдлаар 298 хүнийг эрүүлжүүлж, 26 тохиолдолд хүчирхийлэл үйлдэхдээ ашигласан зэвсэг, зэвсгийн чанартай зүйлийг хураан авсан байна.


Хохирогчтой хийсэн ярилцлагаар хохирогч бичиг баримт болон шаардлагатай хэрэглээний эд зүйлээ авахын тулд цагдаагийн байгууллагад хандахаа мэддэггүй, зарим хохирогчийн хувьд цагдаагийн байгууллагын тусламж авч чадаагүй тохиолдол ч байна.

Би сумын цагдаад хандсан. Учир нь нөхөр маань намайг зодож, хөлийг минь хугалсан байсан. Цагдаа ямар нэгэн арга хэмжээ аваагүй, Ийм байдал байнга давтагддаг тул 2 хүүхдээ аваад зугатаж аймгийн төвд түр амьдрахаар болсон. Нөхрөөсөө бичиг баримтыг ав өгөөч гэж хүссэн боловч сумынхаа цагдаад ханд гэсэн. Сумын цагдаа болохоор та одоо аймагт байгаа болохоор манайд хамааралгүй гэсэн.

Хохирогчтой хийсэн ярилцлагаас

Цагдаагийн алба хаагч дийлэнх тохиолдолд хүчирхийлэл үйлдэгчид аман хэлбэрээр шаардлага тавьдаг бөгөөд тухайн нөхцөлд шаардлагыг эсэргүүцэхгүй бол ямар нэгэн хэлбэрээр албадлага хэрэглэдэггүй байна. Өөрөөр хэлбэл, цагдаагийн алба хаагчаас тавьж буй шаардлага нь дийлэнх тохиолдолд зөвхөн тухайн нөхцөл байдалд шууд хэрэгжүүлэхэд чиглэсэн шаардлага байдаг байна.

Харин цагдаагийн ажилтнаас тавьж буй шаардлага нь цаашид буюу урт хугацаанд сахин биелүүлэх нөхцлийг тусгасан(дахин согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэх, гэр бүлийн гишүүдээ айдаст автуулах зэрэг үйлдэл хийхгүй байхыг анхааруулсан), мөн энэхүү шаардлагыг зөрчсөн нөхцөлд хуулийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болохыг сануулсан мэдээллийг агуулдаггүй байна.



Зураг 16. Цагдаагийн албан хаагчийн шаардлага

Үнэлгээний хүрээнд хийсэн ярилцлагаар цагдаагийн алба хаагчид “хүчирхийлэл үйлдэгчийн үйлдэл, эс үйлдэл нь гэмт хэрэг, эсхүл зөрчилд хамаарахгүй бол ямар нэгэн арга хэмжээ авах боломжгүй байдаг” гэсэн бэрхшээлийг дурьдаж байсан бол хохирогчид “цагдаагийн алба хаагчаас тавьж буй шаардлага, сануулга нь илүү урт хугацааны бөгөөд эргэх хяналттай, зөрчвөл хариуцлага хүлээлгэх боломжтой байх” гэдгийг дийлэнх нь илэрхийлж байсан.

Цагдаагийн авч буй арга хэмжээ оновчгүй үр дүнгүй байна. Зарим цагдаа ирээд ажил их байхад аргалаад унтуулж болдоггүй юм уу гэдэг. Ер нь хүчирхийлэл үйлдэж буй архины хамааралтай этгээдүүдийг зөвхөн түр зуур эрүүлжүүлээд гаргах биш цаашлаад хяналт тавиад, сэтгэл зүйн зөвлөгөө өгч болохгүй юу? Арга хэмжээ нь чангахан байгаасай. Манай бага хүүхэд яг аавынхаа хийдэг үйлдлийг хийдэг болсон. Хүүхдүүдтэй тоглохдоо үсдэж, хоолойг нь боодог.

Хохирогчтой хийсэн ярилцлага

Цагдаагийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д “Цагдаагийн алба хаагч, олон нийтийн цагдаа нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, зөрчлийг арилгуулах, учирч болох хор хохирлыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх зорилгоор хүн, хуулийн этгээдэд тодорхой үйлдлээс татгалзах, эсхүл үйлдэл хийх шаардлага тавьж болно.” 23.7-д “Цагдаагийн алба хаагч, олон нийтийн цагдаагийн шаардлагыг биелүүлээгүй, эсэргүүцсэн, эсхүл хуулийн дагуу явуулж байгаа ажиллагаанд нь саад учруулсан бол албадан гүйцэтгэж, гэм буруутай этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэсэн бол Зөрчлийн тухай хуулийн 15. 2 дугаар зүйлийн 2-т “Хууль сахиулагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй... бол ...хүнийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж заасан байна.

Иймд цагдаагийн алба хаагч гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээллийн дагуу хүрэлцэн очиж, аюулгүй байдлыг шалгахын зэрэгцээ шаардлага тавих арга хэмжээг өргөн агуулгаар хэрэгжүүлж, эргэж шалгах зэргээр хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх хэлбэрээр хэрэгжүүлэх нь илүү үр нөлөөтэй байх үндэслэлтэй байна.

Өөрөөр хэлбэл, хүчирхийллийн болзошгүй эрсдлийг бууруулахад анхаарч хүчирхийлэл үйлдэгчээс тодорхой үйлдэл, эс үйлдэл хийхийг хориглосон шаардлагыг бичгээр тавьж, хариуцлагыг сануулах, эргэж хянах журмаар хэрэгжүүлэх боломжтой юм.


3.3. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагааны явцад хохирогчийн аюулгүй байдлыг хангах үүргийн хэрэгжилт

Шинэчлэн баталсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль хэрэгжиж эхлэхээс өмнө буюу 2015 онд 1323 хүнд гэр бүлийн

хүчирхийллийн гэмт хэргийн улмаас эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж, зөрчил үйлдсэн 898 хүнд 11.3 сая төгрөгөөр торгох, 555 хүнд баривчлах шийтгэл ногдуулсан байна.⁴⁸

2016 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн (2004 он) дагуу Иргэний хэргийн шүүхийн шийдвэрээр 62 хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээг оногдуулжээ.⁴⁹

ГБХТ тухай хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжиж эхэлсэн 2017 онд 1269 хүнийг гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гэмт хэрэгт сэжигтнээр тооцон шалгаж, зөрчил үйлдсэн 1480 хүнд 37.3 сая төгрөгөөр торгох, 2889 хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулсан байна.



Зураг 17. Зөрчлийн улмаас шийтгэл хүлээсэн байдал

2018 оны эхний 10 сарын байдлаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 43 хүнд нийт 5197.0 мянган төгрөгөөр торгох шийтгэл ногдуулсан байна.⁵⁰

Үүнээс гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн гаралт буурсан боловч гэр бүлийн хүчирхийллийн зөрчил үйлдсэн этгээдэд шийтгэл оногдуулах байдал 3 дахин нэмэгдэж, түүний дотор хүчирхийлэл үйлдэгч шийтгэлээ өөрөө хүлээх буюу баривчлах шийтгэл оногдуулалтын хувь хэмжээ 2 дахин нэмэгдсэн байна.⁵¹


48 Цагдаагийн байгууллагын статистик мэдээлэл. <https://www.police.gov.mn>

49 Шүүхийн статистик. 2016 он.

50 Цагдаагийн байгууллагын статистик мэдээлэл. <https://www.police.gov.mn>

51 Торгох шийтгэл оногдуулсан тохиолдолд ихэвчлэн торгуулийг хохирогч, гэр бүлийн бусад гишүүд төлдөг байна.

2015 онд гэр бүлийн хүчирхийллийн улмаас хүчирхийлэл үйлдэгчид оногдуулсан шийтгэлийн 62%-ийг баривчлах шийтгэл эзэлж байгаа бол 2018 оны эхний 10 сарын байдлаар баривчлах шийтгэл 98% болж нэмэгдсэн.



Зураг 18. Хүчирхийлэл үйлдэгчид оногдуулсан шийтгэл/

Ийнхүү хүчирхийлэл үйлдэгч хариуцлагын гадна үлддэг байсан байдлыг халсан нь дэвшилттэй боловч хүлээлгэж буй хариуцлага үр дүнтэй эсэх асуудал мөн анхаарал татсан хэвээр байна.

Хэдийгээр цагдаагийн байгууллага хүчирхийллийг цаг тухайд нь яаралтай таслан зогсоож чадсан хэдий ч хүчирхийлэл үйлдэгчид хүлээлгэх хариуцлага нь үр дүнтэй биш бол цагдаагийн байгууллагад дахин хандах хохирогчдын тоо болон хандах иргэдийн мэдээлэл ч буурч болох юм.

Нөхрийг агсарч цамнахаар нь айгаад цагдаа дууддаг. Цагдаа нөхрийг авч явдаг боловч маргааш өглөө нь тавиад явуулчихдаг. Тэгээд чи цагдаа дууддаг хэн бэ гээд бөөн юм болдог болохоор нь дахиж дуудлага өгөхөө больсон.

Хохирогчтой хийсэн ярилцлагын тэмдэглэлээс

2018 оны эхний 10 сарын байдлаар цагдаагийн байгууллагын 102 дугаарын утсанд ирсэн 1216 тохиолдлын 11 орчим хувийг (129 тохиолдол) давтан дуудлага эзэлж байна.⁵²

Зөрчлийн тухай хуульд гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдэд ямар нэгэн сонголтгүйгээр зөвхөн баривчлах шийтгэл оногдуулахаар заасан⁵³ боловч хүчирхийлэл үйлдэгч нь “жирэмсэн эмэгтэй, арван дөрөв хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эцэг, эх, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан

⁵² Мэдээлэл, шуурхай удирдлагын газрын бүртгэл. 2018 он.

⁵³ Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйл.

хүн, баривчлах шийтгэл эдлүүлэхэд саад болохуйц өвчтэй” бол баривчлах шийтгэл оногдуулахгүй бөгөөд нэг хоногийг арван таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тооцож торгохоор байна⁵⁴.

Нөгөө талаар хүчирхийлэл үйлдэгчид зан үйлд нөлөөлөх албадан сургалтанд хамруулах албадлагын арга хэмжээг оногдуулахаар хуульчилсан нь дэвшилттэй боловч зөвхөн баривчлах шийтгэл дээр нэмж оногдуулах буюу ямар нэгэн сонгох хувилбаргүй байна.

Өөрөөр хэлбэл, хүчирхийлэл үйлдэгч баривчлах шийтгэлээ эдлэх буюу баривчлах байранд байх хугацаандаа тус сургалтанд хамрагдахаар байна.

Гэтэл дээр дурьдсан үндэлэлээр торгох шийтгэл хүлээсэн этгээдийг албадан сургалтанд хамруулах боломжгүй болж байна.

Иймд хүчирхийлэл үйлдэгчид хүлээлгэх хариуцлагын төрлийг эргэн харах, хүчирхийлэл үйлдэгчид тодорхой эрхийг нь хязгаарлах болон баривчлах шийтгэлийг сонголттой оногдуулах, мөн аль ч нөхцөлд албадан сургалтад хамрагдах нөхцөлийг хуульчлах нь үр дүнтэй байна.

Нөхөр 30 хоногоор баривчлагдсан. Энэ хугацаанд эдийн засгийн хүнд байдалд орсон. Нялх хүүхэдтэй, ажил хийх боломжгүй, банкны зээлтэй. Уг нь баривчлуулахгүйгээр дахин хүчирхийлэхгүй байх талаар ойлгуулж, ухааруулаад сургалтанд хамруулаад өгөөсэй гэж бодож байсан юм.

Хохирогчтой хийсэн ярилцлагаас

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийг шалган тогтоох ажиллагааг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу, зөрчил шалган тогтоох ажиллагааг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар тус тус зохицуулж байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд зааснаар цагдаагийн байгууллага нь гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг шалгах ажиллагааг хэрэгжүүлэх явцдаа хохирогчийг мэдээллээр хангах, хохирогчийн аюулгүй байдалд эрсдэл учирч болзошгүй нөхцлийг харгалзан хүчирхийлэл үйлдэгчид таслан сэргийлэх арга хэмжээ авах, хохирогч, гэрчийн мэдүүлэг, хувийн мэдээллийг нууцлах үүргийг хүлээсэн.

55

54 Зөрчлийн тухай хуулийн 3.5 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэг.

55 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 8 дугаар зүйл.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд “Яллагдагч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахгүй байх, түүнийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор ...тодорхой газар очих, тодорхой хүнтэй уулзахыг хориглох, тогтоосон замаар зорчихыг яллагдагчид даалгаж, хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг”-г авч болохоор заасан байна.

Харин зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад холбогдогчийг 24-72 цагийн хугацаагаар саатуулахаас өөрөөр хохирогчид саад учруулж болзошгүй нөхцөлд ямар нэгэн арга хэмжээ авах зохицуулалт байхгүй байна.

Түүнчлэн зөрчил шалгах ажиллагааг дуусгаад зөрчлийн хавтаст хэргийг холбогдогчид танилцуулахаар заасан боловч энэ тохиолдолд гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор тэдгээрийн мэдүүлэг болон биеийн байцаалтыг нууцлах арга хэмжээг авах талаар зохицуулалт байхгүй байгааг анхаарах шаардлагатай байна.

Мөн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчил, гэмт хэргийн тохиолдолд хохирогчид гэмтэл, хохирол учирсан байхыг шаардахгүй, харин хүчирхийллийг тогтмол буюу байнгын шинжтэй үйлдэж байгаа нь гэмт хэрэгт тооцох нөхцөлийг бүрдүүлэхээр хуульд заасан байна.⁵⁶


Эрүүгийн хуульд заасан “байнгын” гэсэн шинж нь шууд давтамжийн тоо, эсхүл зөрчлийг удаа дараа үйлдсэнд хамаарах асуудал биш бөгөөд хүчирхийлэл тогтвортой байдлаар үргэлжлэн үйлдэгддэг болохын илэрхийлэл юм.⁵⁷

2017 онд бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчдын мэдүүлгээс үзэхэд 507 хохирогч 1 жил хүртэл хугацаанд хүчирхийлэл үргэлжилж байна гэсэн бол 146 хохирогч 1-3 жил, 43 хохирогч 3-5 жил, 13 хохирогч 5-8 жил, 21 хохирогч 8-аас дээш жил хүчирхийлэлд өртсөн гэжээ.⁵⁸

56 Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль.

57 Үнэлгээний хүрээнд УЕПГ-ын сургалт хариуцсан прокурортой хийсэн ярилцлагаас. 2018 он

58 Цагдаагийн байгууллагын статистик мэдээлэл. 2017 он.



Зураг 19. Гэмт хэрэгт өртсөн гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн хүчирхийлэл дарамтад байсан хугацаа (жилээр)

Гэвч практикт энэхүү шинжийг гэр бүлийн хүчирхийллийн үйлдэгдсэн давтамж буюу зөрчлийг хэдэн удаа үйлдсэн г.м тоон үзүүлэлтээр хэмжих нь түгээмэл байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдээд жилдээ 3-5 удаа баривчлагдаж байгаа хүмүүс байна. Гэтэл хуулиараа бол 3-аас дээш удаа гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн бол шууд эрүүгийн хариуцлага хүлээлгэх ёстой.

ШШГЕГ-ын харьяа Баривчлах төвийн нийгмийн ажилтантай хийсэн ярилцлагаас

Үүнээс дүгнэхэд хүчирхийлэл үйлдэгчид ял шийтгэл хүлээлгэх, зөрчил, гэмт хэргийг шалган тогтоох харилцааг Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль болон холбогдох процессын хуулиар зохицуулж байгаа ч эдгээр хуулийн зохицуулалтын оновчгүй байдал нь гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийн дэмжлэг туслалцаа авах эрхэнд бэрхшээл үүсгэж байна.

Мөн эрүүгийн болон зөрчлийн хэрэг үүсгэх, хүчирхийлэл үйлдэгчид ял, шийтгэл оногдуулах асуудал нь прокурор, шүүхийн эрх хэмжээний асуудал хамаарах боловч эдгээр субъектийн хуучинсаг хандлага, бэлтгэгдээгүй байдал ч ялгаагүй цагдаагийн алба хаагчийн үүргийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.

Иймд дээрх чиглэлд эрх зүйн зохицуулалтын шинэчлэлээс гадна шүүгч, прокуроруудыг сургах, бэлтгэх, арга зүйгээр хангах асуудалд анхаарал хандуулах шаардлагатай байна.

Зөрчлийн тухай хуульд гэр бүлийн хүчирхийллийн зөрчил үйлдсэн этгээдийг баривчлахаас гадна албадан сургалтанд хамруулахаар⁵⁹ заасан бол Эрүүгийн хуульд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял оногдуулахгүйгээр, эсхүл ял дээр нэмж зан үйлээ засах сургалтанд хамрагдах үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээг шүүхээс оногдуулахаар⁶⁰ хуульчилсан.

Ийнхүү хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт нь гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдэд хүлээлгэх хариуцлагын нэг төрөл болж хуульчлагдсан бөгөөд зөрчилд үйлдсэн этгээдэд чиглэсэн сургалтыг цагдаагийн байгууллага (Нийслэлд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хариуцаж байна)⁶¹, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд зориулсан сургалтыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага⁶² тус тус хариуцан зохион байгуулж байна.

Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр, журмыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн А/73 дугаар тушаалаар баталсан.

Цагдаагийн байгууллагаас авсан мэдээллээр зан үйлд нөлөөлөх албадан сургалтын загвар хөтөлбөр, сургалтын гарын авлагыг “Монгол өрх” төрийн бус байгууллагатай хамтран боловсруулж, сургагч багш нарыг бэлтгэн, гэр бүлийн хүчирхийллийн зөрчил үйлдсний улмаас 7-30 хоногийн баривчлах шийтгэл хүлээсэн 1925 этгээдэд 16-56 цагийн багц сургалтыг шүүхийн шийдвэрийн дагуу зохион байгуулсан байна.⁶³

Зан үйлд нөлөөлөх сургалтын загвар хөтөлбөр, сургалтын гарын авлагатай болж, багш нарыг бэлтгэж байгаа нь сайшаалтай боловч бодит байдалд хэрэгжилт хангалтгүй, үр дүнгүй байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдээд баривчлах шийтгэл хүлээсэн этгээдүүдэд зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг цагдаагийн байгууллага хариуцахаар заасан боловч орон нутагт сургалт явуулах мэргэжлийн багш, сургалтын анги танхим, хэрэглэгдэхүүн, сургалт явуулсан багш нарт олгох зардал шийдвэрлэгдээгүй байна.

*Эх сурвалж: ЦЕГ-ын Дэд дарга, цагдаагийн хурандаа
З.Дашдаваагийн илтгэлээс 2018-11-27*

59 Зөрчлийн тухай хуулийн 4.5, 5.4 дүгээр зүйл.

60 Эрүүгийн хуулийн 7.3 дугаар зүйлийн 2.2 дахь заалт.

61 Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын журмын 2.1 дэх хэсэг.

62 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4 дэх хэсэг.

63 Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх Цагдаагийн байгууллагын ажиллагаа сэдэвт илтгэл. ЦЕГ-ын дэд дарга, цагдаагийн хурандаа З.Дашдаваа. 2018 он.

Учир нь тус журмаар сургалтын хөтөлбөрийн агуулга, чиглэлийг хэт ерөнхий зохицуулснаас гадна орон нутаг бүрт өөр өөр ялгаатай байдлаар явуулах нөхцөлийг бүрдүүлсэн нь хууль нэг мөр хэрэгжих боломжийг алдагдуулахын зэрэгцээ агуулга, арга зүйд нь ач холбогдол өгөхгүй ёс төдий хандах, мэргэжлийн бус байгууллага, хувь хүнийг гэрээлэн оролцуулах зэргээр хуулийн дагуу хүлээлгэх шийтгэл гэхээс илүү иргэдэд мэдээлэл өгөх үйл ажиллагаатай адилтган хэрэгжүүлэх нь түгээмэл байна.

Энэ нь нэг талаас тус сургалтыг явуулах багш, боловсон хүчнийг бэлтгээгүй, нөөц дутмаг, сургалт явуулах байр, гарын авлага болон зардлыг шийдвэрлээгүйтэй холбоотой төдийгүй Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр, журмын зохицуулалтын алдаатай байдалтай ч холбоотой байна.

Тухайлбал, Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын журамд зан үйлд нөлөөлөх сургалт нь сэтгэл зүй, эрх зүй, бясалгалын гэсэн төрөлтэй⁶⁴ бөгөөд албадан сургалтын төлөвлөгөөг шийтгэл хүлээсэн этгээдийн шинж байдлаас хамаарч боловсруулж, тухайн нэгжийн дарга батлахаар⁶⁵ заажээ. Түүнчлэн сэтгэл зүйн болон эрх зүйн сургалтанд хамаарах ерөнхий чиглэлийг заасан⁶⁶ бол бясалгалын сургалтын хувьд чөлөөтэй буюу тухайн байгууллагын даргын тушаалаар баталсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу явуулахаар заасан⁶⁷ байна.

Үүний дагуу орон нутаг бүрт сургалтын өөр өөр агуулга бүхий хөтөлбөр баталж байгаа бөгөөд бясалгалын сургалт нэрээр лам, санваартанг оролцуулан шашны зан үйл үйлдэх, шашин сурталчлах ажиллагааг явуулж байгаа тохиолдол байна.

Манай нөхөр шүүх хурал дээр “Би засарсан, дахиж эхнэрээ зодохгүй” гэсэн. Шүүгч зан үйлээ засах сургалтад хамрагдсан уу, гэхэд “Ламд очиж ном уншуулсан” гээд гандангийн тасалбар гаргаж үзүүлсэн.

Мэдээлэл цуглуулагчийн тэмдэглэлээс

Ийнхүү зан үйлд нөлөөлөх сургалт үр дүнгүй зохион байгуулагдаж байгаа нь хүчирхийлэл дахин давтагдах эрсдлийг бууруулахад бодитой нөлөөлж чадахгүй байна.

64 Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөрийн 8, 9 дүгээр зохицуулалт.

65 Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын журмын 2.2 дахь хэсэг

66 Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөрийн 9.2 дахь хэсэг.

67 Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөрийн 8.1.3 дахь заалт.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Цагдаагийн байгууллага нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд хохирогчдод хамгаалалт, үйлчилгээ үзүүлэх тусгай нэгж болон үүрэг хүлээсэн алба хаагчдыг мэргэжил, арга зүйгээр хангах бүтэц, цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагаандаа баримтлах аргачлалыг тогтоосон журам болон үйл ажиллагааны стандартыг батлан мөрдүүлсэн зэрэг зохион байгуулалт, орчин нөхцлийг сайжруулсан олон сайн туршлага байгааг энэхүү үнэлгээгээр тогтоолоо.

- 2014 оноос НЦГ-ын харьяанд түр хамгаалах байрыг байгуулж, 24 цагийн дуудлагын "107" тусгай дугаарын утас, 2016 онд ЦЕГ, НЦГ-т гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг дагнан хариуцсан хэлтсийг байгуулан ажиллуулж эхэлсэн эдгээр нэгжийн үйл ажиллагаа нь жигдэрч, үйлчилгээ нь тогтворжсон байна.
- Аймаг, дүүргийн цагдаагийн газар, хэлтэст гэр бүлийн хүчирхийллийн асуудал хариуцсан мэргэжилтний орон тоог бий болгож, өнөөдрийн байдлаар 60 орчим мэргэжилтэн ажиллаж байна.
- 2015 оноос эхлэн цагдаагийн байгууллага нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийг тусгайлан гаргаж эхэлсэн бол 2018 оноос Мэдээлэл, шуурхай удирдлагын төв буюу 102 дугаарын утсанд ирсэн мэдээллийн бүртгэлд гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой дуудлага, мэдээлэл, түүний дагуу авсан арга хэмжээний талаарх мэдээллийг бүртгэж эхэлсэн байна.
- Цагдаагийн алба хаагчийн ажлын байрны тодорхойлолт, тодорхой чиглэлийн алба, нэгжийн үйл ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлтэд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр гүйцэтгэх ажил үүрэг, түүний үр дүнг тооцох нөхцөл тусгагдсан байна.
- Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх журмын хүрээнд ЦЕГ-ын даргын тушаалаар Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаанд мөрдөх журмыг шинэчлэн баталсан бол Шуурхай удирдлагын албаны үйл ажиллагааны журамд гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээлэл хүлээн авахад анхаарах асуудал болон авах арга хэмжээг тусган хэрэгжүүлж байна.
- Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх,

хохилогч хамгаалах чиглэлд давхардсан тоогоор төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн 12500 гаруй алба хаагчийг сургалтад хамруулжээ.

- Цагдаагийн алба хаагч нь гэр бүлийн хүчирхийллийн талаарх дуудлага, мэдээлэл бүрт хариу үйлчлэл үзүүлж хэвшсэн бөгөөд дуудлагын дарааллыг тогтоохдоо аюултай нөхцөл байдлаас гадна гэр бүлийн хүчирхийллийн дуудлага гэдэгт анхаарал хандуулдаг болсон байна.
- “Гэр бүлийн хүчирхийллийн мэдээллийн сан” үүсгэж, дуудлага мэдээллээр ажиллахад ашиглаж эхэлсэн бөгөөд эхний ээлжинд нийслэлийн хэмжээнд эргүүлийн цагдаагийн алба хаагч дуудлага, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, үйл ажиллагаандаа ашиглах “Таблет” олгож, хүчирхийллийн түүхийг шалгах, хохирогчид ашигтай буюу түүний эрүүл мэнд, амь насыг хамгаалах шийдвэр гаргахад ашиглах боломж бүрдүүлэхээр ажиллаж байна.

Гэвч цагдаагийн алба хаагчийн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар хүлээсэн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах, хүчирхийлэл дахин давтагдах эрсдлийг бууруулах үүргийн хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай байгааг үнэлгээний дүн харууллаа.

- Хууль хэрэгжиж эхлэхтэй зэрэгцүүлэн холбогдох журам, стандартыг батлан мөрдүүлсэн нь сайшаалтай хэдий ч зарим журмын зохицуулалт нь төдийлөн оновчтой бус, чухал зохицуулалтыг орхигдуулсан, хэрэгжүүлэн ажиллахад бэрхшээлтэй байдаг зэрэг дутагдал байна. Тухайлбал, Аюулын зэргийн үнэлгээ хийх журам
- Цагдаагийн алба хаагчаас гэр бүлийн хүчирхийллийн дуудлагыг үл ойшоох, ноцтой гэж үзэхгүй байх, гомдлоо заавал бичгээр гаргахыг шаардах зэргээр хохирогчид чирэгдэл учруулах тохиолдол цөөнгүй, урьдчилан сэргийлэх, дахин давтагдаж болзошгүй эрсдлийг бууруулах, эргэж хяналт тавих ажиллагаа хангалтгүй хийгдэж байна.
- Цагдаагийн анхан шатны нэгж дээр ажиллаж байгаа алба хаагчид нь хуулиар хүлээсэн үүргийг танилцуулах байдлаар сургалт хийж байгаа нь үүргээ хэрэгжүүлэх арга зүйн мэдлэг, ур чадвар дутмаг, хуулиар өөрт олгогдсон эрх хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх талаарх ойлголт сул байгаа нь тогтоогдсон.

- Цагдаагийн алба хаагчдыг чадавхижуулах сургалт нь албан ёсны буюу заавал хамрагдсан байх шаардлагад хамаардаггүй, мөн практикт ажиллаж байгаа алба хаагчдыг давтан сургах (ур чадвар олгох), мэргэшүүлэх ажил тасралтгүй хийгдэж чадахгүй байлаа.
- Мэдээллийн санд дуудлага, мэдээлэлд үндэслэсэн явцуу мэдээллийг хамруулсан, мэдээллийг орон нутагт үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагч болон хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагч ашиглах боломж хангалтгүй байна.
- Аюулын зэргийн үнэлгээг хуульд заасан үндсэн зорилгын дагуу биш нотолгооны хэрэгсэл буюу хүчирхийлэл үйлдэгдсэн эсэх, хүчирхийлэл үйлдэгчид хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээг тогтоох нотлох баримт болгон ашиглах болсон нь цагдаагийн байгууллагад цаг хугацаа, санхүүгийн нөөц, шуурхай ажиллах боломжид сөргөөр нөлөөлж байна.
- Хохирогчдод зориулсан мэдээллийн хуудсаар анхан шатны нэгж дээр ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчид хангагдаагүй, мэдээллийн хуудсыг хохирогчдын хэрэгцээнд нийцсэн, хүртээмжтэй хэлбэрээр хэвлэн түгээх ажил орхигдсон байна.
- Цагдаагийн алба хаагч нь хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээг сонгон хэрэглэхдээ дийлэнх хувийг ойр дотны хүний хамгаалалтад өгөх журмаар буюу бусдад үүрэг хүлээлгэх байдлаар хэрэгжүүлж байгаа нь үр дүнгүй бөгөөд зарим тохиолдолд хохирогчид эрсдэл учруулж болзошгүй байна.
- Хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагчийн хамтарсан багийн гишүүнээр ажиллах нөхцөл, боломжийг хангаж, тодорхой дэмжлэг, арга зүй, аргачлалаар хангах ажлыг эрчимжүүлэх ажил хангалтгүй байгаагаас хүчирхийллийн болзошгүй эрсдлийг эрт шатанд илрүүлэх, хохирогчийн аюулгүй байдалд үргэлжлүүлэн хяналт тавих ажил хангалтгүй хэвээр байна.

ТАВ. ЗӨВЛӨМЖ

Үнэлгээний дүгнэлтэд үндэслэн гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМАНД

1. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн А/37 дугаар тушаалаар баталсан Аюулын зэргийн үнэлгээ хийх журмыг хуульд нийцүүлэн шинэчилж, шалгуурыг тодорхой, оновчтой болгох;
2. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн А/73 тушаалаар батлагдсан Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр, сургалтын журмыг шинэчлэн баталж, сургагч багшийн нөөцийг бүрдүүлэх, төв, орон нутагт нэгдсэн стандартаар хэрэгжүүлэх нөхцлийг хангах;
3. Цагдаагийн алба хаагчдыг давтан сургах болон Хууль сахиулах их сургуулийн сургалтын хөтөлбөрт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль тогтоомжийг хэрэглэх үр чадвар олгох чиглэлээр тусгагдсан агуулга, арга зүйд тусгай үнэлгээ хийж, сайжруулах арга хэмжээ авах;
4. Нутаг дэвсгэр, хүн амын тоо, гэр бүлийн хүчирхийллийн тархалт болон Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан Цагдаагийн байгууллагын бүтэц, орон тооны жишиг нормативыг харгалзан эргүүлийн үүрэг гүйцэтгэх алба хаагчид болон хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагчийн орон тоог нэмэгдүүлэх, техник хангамжийн хүртээмжийг сайжруулахад анхаарах;
5. Цагдаагийн ерөнхий газар, Нийслэлийн цагдаагийн газарт ажиллаж байгаа гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нэгжийн үндсэн зорилгын хэрэгжилт, ажлын ачааллыг харгалзан мэргэшсэн алба хаагчдын орон тоог нэмэгдүүлэх.

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛД

1. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээлэлд үндэслэн өсөлт, бууралтанд нөлөөлж буй шалтгаан нөхцөлд дүн

шинжилгээ хийж, зөвлөмж гаргах, практикт хэрэгжиж байгаа сайн туршлагыг өргөжүүлэх арга хэмжээг төлөвлөн, зохион байгуулах;

2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлд хүлээсэн цагдаагийн алба хаагчийн үүргийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг хагас жил тутам Дэд зөвлөлөөр хэлэлцэх, тодорхой чиглэл, даалгавар өгөх, үр дүнг олон нийтэд нээлттэй танилцуулах арга хэмжээг авч хэвшүүлэх;
3. Хууль хэрэгжилтийн талаархи нэгдсэн тайланг гаргаж Засгийн газар, Улсын Их хурлаар хэлэлцүүлэх ажлыг жил бүр зохион байгуулах;
4. Алба хаагчдад хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх үр чадвар олгох давтан болон мэргэшүүлэх албан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж, сургалтыг тогтвортой эрхлэн явуулах зохион байгуулалт, төсвийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авах;
5. Салбар зөвлөлийн хуулиар хүлээсэн мэргэжилтнүүдийг сургах, арга зүйгээр хангах, хамтарсан багийг дэмжин ажиллах үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангах чиглэлд тусгай төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх;
6. Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтыг хөгжүүлэхэд анхаарч, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн байгууллагуудыг дэмжих, хамтран ажиллах хөтөлбөр хэрэгжүүлэх;
7. Иргэдэд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль тогтоомжийг сурталчлан таниулах ажлын үр дүн, цар хүрээг нэмэгдүүлэхэд анхаарч, ялангуяа мэдээлэл авах боломж нь хязгаарлагдмал (алслагдмал хөдөө орон нутагт амьдарч байгаа, олон нийтийн мэдээллийн хэрэгслээс мэдээлэл авах боломжгүй, бичиг, үсэг мэдэхгүй гэх мэт) болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд (ялангуяа хэл яриа, сонсголын бэрхшээлтэй), үндэсний цөөнхийн хэрэгцээнд нийцсэн хэлбэрээр зохион байгуулах;
8. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хүний амь нас хохирсон тохиолдол бүрийг судалж дүгнэлт гаргах прокурорын байгууллагын үүргийн хэрэгжилтийг шаардаж, гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг арилгуулах чиглэлд хамтын ажиллагааг идэвхижүүлэх;

9. Хууль хэрэгжилтийн практикт үүсээд байгаа бэрхшээлийг харгалзан эрх зүйн зохицуулалтыг дараахь чиглэлээр боловсронгуй болгох саналыг боловсруулж, Засгийн газарт уламжлах:

- Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулсан Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт 2.700.000-10.000.000 төгрөгийн торгох ял нэмж оруулахаар тусгасныг хасах;
- Зөрчлийн тухай хуульд заасан хүчирхийлэл үйлдэгчид хүлээлгэх хариуцлагын төрлийг эргэн харж, торгох шийтгэлийг оногдуулахгүй байх, тодорхой эрхийг нь хязгаарлах болон баривчлах шийтгэлийг сонголттой оногдуулах, мөн аль ч нөхцөлд албадан сургалтад хамрагдах нөхцлийг хуульчлах;
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор зөрчил шалгах ажиллагааны явцад хүчирхийлэл үйлдэгчид “тодорхой газар очих, тодорхой хүнтэй уулзахыг хориглох” үүргийг даалгах, зөрчлийн хавтаст хэргийг танилцуулахдаа гэрч, хохирогчийн мэдүүлэг болон биеийн байцаалтыг нууцлах зэрэг зохицуулалтыг нэмж тусгах.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАРТ

1. Аюулгүй байдлын үнэлгээг хүчирхийллийн тохиолдол бүрт хийж, хохирогчийн аюулгүй байдлыг яаралтай хамгаалахтай холбоотой шийдвэр гаргах үндэслэл болгох арга зүйд эргүүлийн үүрэг гүйцэтгэдэг алба хаагч, хэсгийн байцаагч, хэсгийн төлөөлөгчийг нэн тэргүүнд сургах;
2. Эргүүлийн үүрэг гүйцэтгэх алба хаагчид болон хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагчийн ажлын байранд тавигдах шаардлагад гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиглэлээр үр чадвар олгох сургалтад хамрагдсан байх шалгуурыг тусгах;
3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үр чадвар олгох давтан сургалтын төлөвлөгөөг баталж, сургалтыг батлагдсан агуулга, арга зүйн дагуу тодорхой үе шаттай зохион байгуулах, энэ хүрээнд сургалтын видео хичээл бэлтгэж, зайны сургалтын аргачлалыг ашиглах;

4. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлд анхаарч, ялангуяа хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагчийн хамтарсан багийн гишүүнээр ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлж, тодорхой дэмжлэг, арга зүй, аргачлалаар хангах ажлыг эрчимжүүлэх, хамтарсан багт ажилласан байдлыг ажил дүгнэх үндсэн үзүүлэлтэд тооцож үнэлж байх;
5. Гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдээллийн санг шаардлагатай мэдээллээр өргөжүүлж, эргүүлийн болон анхан шатны нэгж дээр ажиллаж байгаа цагдаагийн алба хаагч нээлттэй ашиглах боломжийг бүрдүүлж, өдөр тутмын үйл ажиллагаанд нь ашиглаж хэвшүүлэх;
6. Хохирогчид зориулсан тусламжийн хуудсыг тодорхой, ойлгомжтой, хэрэглэхэд хялбар байдлаар боловсруулж, нэгдсэн журмаар хүртээмжтэй хэлбэрээр хэвлэн олшруулж, өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглах нөхцөлийг бүрдүүлэх;
7. Хохирогчид зориулсан тусламжийн хуудсыг харааны бэрхшээлтэй болон монгол хэл мэдэхгүй үндэсний цөөнх зэрэг тусгай хэрэгцээтэй иргэдэд зориулсан хэлбэрээр тусгайлан боловсруулж, ашиглах;
8. Цагдаагийн алба хаагчаас хүчирхийлэл үйлдэгчид тавих шаардлагын агуулгыг өргөжүүлж, хүчирхийлэл үйлдэгчид тодорхой үйлдэл, эс үйлдэл хийхийг хориглох, зөрчсөн нөхцөлд хүлээлгэх хариуцлагыг бичгээр сануулж, хэрэгжилтийг тогтмол эргэж хянах журмаар хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх хэлбэрээр хэрэгжүүлэхэд анхаарах;
9. Шуурхай удирдлагын албаны үйл ажиллагааг зохицуулах журамд дуудлага тасарсан, хаанаас, хэн залгаж байгаа нь тодорхойгүй дуудлагын дагуу авах арга хэмжээ, хэл яриа, сонсголын бэрхшээлтэй иргэдийн дуудлагыг хэрхэн авах, шалгах талаар нарийвчилсан зохицуулалтыг тусгаж, хэрэгжилтийг хангах арга хэмжээ авах;
10. Хохирогчийг аюулгүй байдлын түр хамгаалалтаар хангах үйл ажиллагаанд баримтлах стандартыг боловсруулж, мөрдүүлэх.